

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-41
<hr/>	
1. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	5-7
2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг	7-10
3. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан	10-41

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 4 дүгээр сарын 28-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 35 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Ө.Шижир;

Чөлөөтэй: Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Пүрэвдорж, Ч.Ундрэм;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл.

**Нэг.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

**Б.Баярбаатар:** 1.Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын 2026.04.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 10  
Бүгд: 19  
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Уг асуудлыг 11 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 7  
Бүгд: 19  
63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

## ***Гурав.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Л.Золзаяа, Л.Төгсцэнгэл, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, мөн газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Х.Сайнхишиг, мөн газрын ахлах референт Д.Цэцэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны талаарх тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Энхтуяа, Л.Гантөмөр, С.Зулпхар, Б.Хэрлэн, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн хариулж, тайлбар хийв.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Б.Хэрлэн нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг сонсов.

*Уг асуудлыг 13 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 36 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр,  
Баасан гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 11 цаг 34 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Б.Баярбаатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Батын Батбаатар гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар ирсэн байна. Лувсаннъямын Гантөмөр гишүүн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн байна. Тогмидын Доржханд гишүүн ирсэн байна. Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна. Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн байна. Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Баттогтохын Чойжилсүрэн гишүүн ирсэн байна. Доржзодовын Энхтуяа гишүүн ирсэн байна. Ирц 56.3 хувьтай, 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг.

3.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан гэсэн 3 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Эхний асуудлаа хэлэлцэнэ.

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар

хэлэлцүүлнэ гэж заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна аа.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Танхимд 9 гишүүн байна. Ирцэд 18 гишүүн орсон байгаа. Ирцдээ орсон гишүүд танхимд хүрэлцэн ирэхийг урья.

Засгийн газраас 2026 оны 4 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Хоёр дахь нь Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын 2026 оны 4 сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэсэн ийм 2 хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна аа.

Танхимд 10 гишүүн боллоо. Саналаа хураачих уу? Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. 7 гишүүн санал хураалтад бэлдсэн байна. Энд байгаагаас Хэрлэн гишүүн, Чойжилсүрэн гишүүн санал хураалтад бэлтгээрэй. Гантөмөр гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй. Лодойсамбуу гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй. Хууль хэлэлцэх эсэх талаар дэгээрээ үг асуулт байхгүй санал хураалтаараа шийдэх юм байна. Хэрлэн гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй. Орчихсон уу? 10 гишүүн Лодой гишүүн орчихсон байна. Хэрлэн гишүүнийх ороогүй байна. 11 боллоо.

Би санал хураалтын томъёолол танилцуулъя. Засгийн газраас 2026 оны 4 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн дэмжиж 57.9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очирын 2026 оны 4 сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй. 47.4 хувиар дэмжигдсэнгүй, тус хуулийг хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэх жагсаалтад оруулах асуудал дэмжигдсэнгүй ээ.

11.44 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Энэ чинь зүгээр нөгөө жагсаалтад орохыг л дэмжиж байгаа байхгүй юу. Уул нь Гантөмөр гишүүнээ энэ бид нар хэлэлцэх суудлын жагсаалтад л оруулж байгаа

байхгүй юу. Баталсан жагсаалтад нэмж оруулж байгаа л. Уг нь Гантөмөр дарга аа энэ зүгээр хэлэлцэх асуудлын жагсаалтад хуулиудын жагсаалтад л оруулж байгаа л даа.

**Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.**

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Лхагвын Мөнхбаатар гишүүн уншиж танилцуулна.

Мөнхбаатар гишүүний микрофоныг.

**Б.Баярбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар тогтоолыг баталсан. Уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 152 дугаар захирамжаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг 2 удаа хуралдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Батсүмбэрэл, Пүрэвдаваа, Тэмүүжин, Уянгахишиг, Цогтбаатар нар ажилласан болно.

Үндсэн хуулийн цэц Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага шилжүүлнэ гэсэн нь Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцэд түүний гишүүн үүргээ гүйцэтгээд гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.

Далдугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасантай нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гаргасан билээ.

Ажлын хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан хамтран ажиллах тухай албан бичгийг явуулж уг дүгнэлттэй холбоотой 267 хуудас материалыг хуулбарыг хүлээн авч судлан үзлээ. Ажлын хэсэг дээрх асуудлыг судлан хэлэлцээд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.4-д хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох гэж Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагааны бүрэн эрхийг тогтоосон байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Мөнхбаатар гишүүнд баярлалаа.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн. Зүйл бүр дээр гишүүд төсөлтэй холбоотой асуулт асууж болно оо. Асуулт асууж, үг хэлж болно.

1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт асууж саналтай гишүүн байна уу? Алга байна. Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Би уг асуудлыг дэмжиж байна аа. Тэгэхдээ энэ Мөнхбаатар дарга болон Байнгын хорооны удирдлагуудаас нэг зүйлийг тодруулмаар байгаа юм. Ер нь энэ Үндсэн хуулийн цэц бол өөрөө хараат бусаар ажиллаж байж үнэндээ Монгол Улсын Үндсэн хуулийн манаач гэдэг үүргээ гүйцэтгэх байгууллага шүү дээ. Тэгээд энэ томилгоотой холбоотой зүйл сүүлийн үед илрээд байгаа хэд хэдэн кэйс гараад байна. Тэгээд ялангуяа Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг татаж авчраад Их Хурлын Тамгын дарга болгосон. Тэгээд эндээс харахад бол улс төрийн намын нөлөөлөл маш их гүнзгийрсэн байна аа. Ерөөсөө энэ тодорхой институцээс нөлөөлөхөөс илүүтэйгээр улс төрийн нам шууд нөлөөлдөг ийм зүйл рүү орчихсон юм байна гэдэг зүйл нотлогдож байгаа юм. Би бол зөв буруугийн тухай ярих гээгүй.

Тэгэхээр цаашдаа бидний энэ ҮХЦ-ээ хараат бус байлгах тухай ойлголт маань алга болчхож байгаа юм. Тэгэхээр Мөнхбаатар дарга цаашдаа ер нь энэ Цэц гэдэг зүйл маань хараат бусаар хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр ажил үүргээ гүйцэтгэхийн тулд ер нь яах юм бэ? Өнөөдөр хүртэл мэдээж энэ дээр зөндөө л анхаарцаасан. Тал талаасаа хуулиуд нь цаг үеэ дагаад өөрчлөгдөөд ирсэн. Нэлээн ахиц гарсан байх ёстой орчин, энэ эрх зүйн орчин маань яг саяын улс төрийн тогтворгүй нөхцөл байдал дээр бол ерөөсөө ахиц алга байна гэдэг ийм дүгнэлтэд хүрчхээд байгаа юм.

Тийм учраас энэ дээр ТББХ ажлын хэсэг гаргаад ер нь энэ байгууллагынхаа бие даасан байдлыг хамгаалах тухайд тодорхой санаачилга гаргаж, тодорхой хэлэлцүүлэг зохион байгуулж ингээд цаашаа явбал яасан юм бэ? Бид нар бол энэ Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо гэдэг энэ 2 байгууллагынхаа бие даасан байдлыг хадгалж байж Монголын ардчилал цаашаагаа тогтвортой байх юм л даа. Тийм учраас нэг байгууллага нь бол үнэндээ бүрэн хамааралд орсон байна гэж ингэж дүгнэхээс өөр аргагүй байдалд хүрч байгаа юм.

Тийм учраас бол ингээд цаашаагаа энэ байдлаараа яваад байх юм бол хамаарал нь нэгнээсээ нөгөөд нь шилжээд байх болохоос биш бие даасан байдал гэдэг зүйлийн баталгаа бол алга болоод байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр яг ямар шийдэлд хүрэх юм бэ гэдэг ийм асуулт. Мөнхбаатар дарга чинь МАН-ын бүлгийн дарга хийж байсан хүн. Их Хурлын дэд дарга хийж байсан хүн.

**Б.Баярбаатар:** Ажлын хэсгийн дарга Мөнхбаатар гишүүн хариулна. Мөнхбаатар гишүүний микрофон.

**Л.Мөнхбаатар:** Гантөмөр гишүүний асуултад хариулъя.

Яг өнөөдөр хэлэлцэж байгаа энэ асуудал бол Үндсэн хуулийн цэцийн 1 дүгээр дүгнэлт байгаа юм. Энэ цэцийн 1 дүгээр дүгнэлт бол энэ хэргийн харьяалал тогтоохтой холбоотой асуудал байгаа юм. Энэ болохоороо Шүүхийн тухай хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй. Эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох энэ бүрэн эрхийг зааж өгсөн байдаг. Түүнээс гадна Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээр аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааныг харьяаллыг нь тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах боломжтой талаар заасан. Энэ бол өөрөө энэ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай энэ хуулийн заалт бол өөрөө Үндсэн хуулийн цэц өөрөө хэрэг маргаан дээр шийдвэрлэх 4 зүйлийг зааж өгсөн байдаг. Энэ дотор байхгүй эрх мэдлийг ингээд заагаад өгчихсөн байгаа учраас энийг нь хүчингүй болгож хасъя гэсэн ийм зохицуулалт байгаа юм гэдгийг хэлье.

Гантөмөр гишүүн бас ер нь энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудлаар ер нь хэрхэн хараат бус ажиллах асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг талаас асууж байна. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болоод Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд бол томоохон өөрчлөлт ороогүй. Ер нь 97 оноос хойш томоохон өөрчлөлт ороогүй ер нь өдийг хүрсэн юм байна лээ. Тэгээд энэ хуулийн төслийг бол одоо шинэчлэн найруулах энэ ажил хийгдэж байгаа. Тэмүүжин гишүүн миний бие оролцоод энэ ажлууд дээр ажиллаж байна. Ингээд энэ хавар Үндсэн хуулийн энэ холбогдох цэцтэй холбоотой 2 хуулийг өргөн бариад намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа гэдгээ танд хэлье.

Ер нь энэ энэнтэй холбоотой асуудлаар Венецийн комисс ирж ажилласан. Бид зөвлөмжийг нь авсан. Үндсэн хуулийн цэцийн гишүүд хараат бус ажиллах Үндсэн хуулийн цэцтэй холбоотой энэ асуудлуудыг ер нь иж бүрнээр нь авч үзэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэр үүднээсээ Венецийн комиссоос томоохон зөвлөмжүүд ирсэн. Энийг би танд хүргүүлье гэж бодож байна.

Ингээд энэ асуудлыг ер нь Үндсэн хуулийн цэц хараат бус ажиллах энэ асуудал уул нь яг уг хуулиар бодлогын хэмжээнд яригдаж шийдвэрлэгдэх боломжтой гэж үзэж байгаа. Ер нь өнөөгийн байдал бол Үндсэн хуулийн цэц хараат ажиллаж байна уу, үгүй юу гэдэг энэ асуудал уул нь ихээхэн маргаан дагуулсан ийм асуудал болж байгаа. Үүнтэй санал нэг байгаа.

**Б.Баярбаатар:** Болчихсон уу?

2 дугаар зүйл. Байхгүй юм байна. Нэг л зүйл.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Мөнхбаатар гишүүн.

**Л.Мөнхбаатар:** Энэ хуулийн төсөл дээр Байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй өөр санал байхгүй байгаа учраас анхны хэлэлцүүлэгтэй хамтран эцэслэн батлах энэ үйл явцыг хамтатган хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Горимын санал гаргаж байна.

**Б.Баярбаатар:** Горимын санал гаргаж байна. Тийм горимын санал гаргаж байна. Тийм горимын саналаар Мөнхбаатар гишүүний гаргасан саналаар горимын

саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдэнэ. Чойжилсүрэн гишүүн санал хураалтдаа бэлдээрэй. Хэрлэн гишүүн, Ариунзаяа гишүүн санал хураалтдаа бэлдээрэй. Ажлын хэсгийн дарга Лхагвын Мөнхбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт.

Санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Лхагвын Мөнхбаатар гишүүн танилцуулна аа.

11.55 цаг

Дараагийн 3 дахь асуудалдаа оръё.

### ***Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан***

Ажлын хэсгийг оруулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.6-д энэ хуулийн 115.2-т заасан тайлан, илтгэл мэдээллийг тухайн байгууллагын дарга байнгын хороо хуралдаанд танилцуулна гэж заасан байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Төрийн албаны зөвлөл Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Л.Золзаяа, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Төгсцэнгэл, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Сайнхишиг, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын ахлах референт Д.Цэцэгмаа гэсэн 3 хүн орж ирэх үү. Нэг зөвлөлийн гишүүн чинь хаачсан юм? Ирэх үү, ирэхээргүй байгаа юу?

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн танилцуулна аа. Цэдэвсүрэн дарга танилцуулгаа хийнэ үү. Индрийн микрофон дээрээс.

**Л.Цэдэвсүрэн:** Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм хүндэт гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль төрийн албаны тухай хуульд заасны дагуу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хэрэгжилтийн тайлан, үүн дотроо Төрийн албаны хууль тогтоомжийн хяналт шалгалтыг хэрхэн зохион байгуулсан, төрийн албан хаагчийн эрх ашгийг хэрхэн хангасан талаарх үйл ажиллагаагаа тайлагнадаг.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны тайланг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хяналт шалгалт, хүний нөөцийн удирдлага, аудит, төрийн албаны шалгалт, төрийн албаны судалгаа шинжилгээ болон төрийн албан хаагчийн сургалт, төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл зөвлөлийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээрх саналын байдлаар багцалж та бүхэндээ танилцуулж байна аа.

Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд төлөвлөгөөт хянан шалгалтыг 2025 онд манай байгууллагаас улсын хэмжээний нийт 330 сум 9 тосгонд очиж ажилласан. Энэ сум тосгонд үйл ажиллагаа явуулдаг 671 төрийн байгууллагын 3402 албан хаагч төлөвлөгөөт бус хянан шалгалтыг нийт 61 төрийн байгууллагын 105 албан хаагч буюу нийлбэр дүнгээрээ 3507 албан хаагчийг хамруулж хийлээ.

Энэхүү хянан шалгалтаар Төрийн албаны тухай хууль болон албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангаагүй, түр орлон гүйцэтгүүлэх болон шилжин сэлгэх журмын зохицуулалтыг хангаагүй нийт 287 зөрчлийг илрүүлж ажилласан.

Хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн саяын үйл ажиллагаатай холбоотой хянан шалгалтаас гадна бид тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн үйлчилгээний байгууллага буюу БСШУ эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний нийт 1579 төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулсан. Ингэж явуулахад нийт 205 төсвийн шууд захирагчийг хууль тогтоомжийг зөрчиж томилсон. Түр орлон гүйцэтгэгчээр томилсон зөрчлийг мөн илрүүлж ажилласан. Хяналт шалгалтыг зөвхөн хянаж шалгаад дуусахаасаа илүүтэйгээр тухайн орон нутагт ажиллаж байгаа төрийн байгууллага болон нийт 36357 албан хаагчийг хамруулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, чиг үүргийн шинжилгээ хийх, хууль тогтоомжийг хэрэглэх талаар сургалт мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан нь илүү үр дүнтэй болж бид нарыг шалгалт хийж байх явцад 176 зөрчил хуульд нийцэгдэж засагдаж арилсан байна аа.

Илэрсэн зөрчлөөс хянан шалгалтын явцад арилгаагүй 187 зөрчлийн асуудлыг зөвлөл хуралдаанаараа хэлэлцэж Төрийн албаны хуульд заасны дагуу 46 тогтоолоор энэ шийдвэрүүдийг бүгдийг нь хүчингүй болгож шийдсэн. Энийгээ хэрэгжилтийнх нь явцад бол хяналт тавьж ажилласнаар 2025 оны оны төгсгөл гэхэд манай байгууллагын гаргасан шийдвэр 87.1 хувьтай хэрэгжсэн ийм үр дүн гарсан.

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн томилгооны зөрчлийг манай байгууллага шууд хүчингүй болгох эрхгүй учраас 129 зөрчлийг арилгах зөвлөмжийг төрийн үйлчилгээний байгууллагын холбогдох албан тушаалтанд өгснөөр энэ зөрчил оны төгсгөл гэхэд арилсан.

Хяналт шалгалтыг орон нутгийн төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний нийт байгууллагыг хамруулж дөрөвхөн сарын дотор хийсэн нь бидний ажлын нэг үр дүн гэж үзэж байгаа. Яагаад гэхээр Төрийн албаны зөвлөл 2025 онд 30 жил үйл ажиллагаа явуулж байгаа ийм байгууллага. 30 жилийн хугацаанд ерөнхийдөө ерөөсөө суманд ингэж нийтлэг байдлаар ажиллаж байсан түүх байгаагүй. Тийм учраас бид нар хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн байгууллага төрийн албан хаагчдад илүү мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ ажлыг хийсэн.

Мэдээж энэ ажлын хүрээнд зөрчлийн тоо бол өнгөрсөн оноос 2.1 хувиар нэмэгдсэн. Яагаад гэхээр өмнө нь хийж байгаагүй энэ хяналт шалгалтын цар хүрээ маш өргөн байсан учраас магадгүй зөрчлийн тоо бол нэмэгдэх ийм үндэслэл болсон болов уу гэж бодож байгаа. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаас гадна манай байгууллага иргэн болон төрийн албан хаагчийг хөдөлмөрлөх эрхээ

зөрчсөн гэсэн ийм өргөдөл, гомдлыг хүлээж авч, үүнийг хянаж шалгадаг. 2025 онд яг энэ чиглэлээр 590 гомдол өргөдөл ирснээс бид нар 589-ийг нь шийдсэн. 589 дотроо 145 эрх бүхий албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч хугацаандаа хэрэгжүүлээгүй шийдвэрүүдийг нь хүчингүй болгох арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой сахилгын шийтгэл ноогдуулсан, албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, мөн халсан тохиолдолд энэ дээр албан ёсоор хуулийн дагуу маргаан үүсгэж шалгадаг. Маргаан үүсгэлт маань өнгөрсөн оноос 45.4 хувийг өнгөрсөн оныхтой харьцуулж үзэхэд 45.4 хувийг сахилгын шийтгэл ноогдуулсан гомдол эзэлж байна.

2024 онтой харьцуулахад өргөдөл гомдлын тоо 41 хувиар өссөн хэдий ч буцаагаад үүсгэсэн гомдлын тоо маань 13.1 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь бидний энэ хууль хэрэгжүүлэх чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зөвлөн туслах болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласантай бол холбоотой энэ эерэг үр дүнгүүд гарсан гэж тооцож байгаа.

Төрийн албан хаагчийг хууль бусаар томилох, чөлөөлөх, түр чөлөөлөх, халсантай холбоотой төрд учирсан хохирлыг буцаагаад буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх үйл ажиллагааг манай байгууллага хийдэг ээ. Өнгөрсөн онд 58 нэхэмжлэлийг шүүхэд гаргаж шүүх болон хууль хяналтын байгууллагатай хамтран идэвхтэй ажилласны дүнд 71 иргэнээс 478.2 сая төгрөгийг буцааж улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгууллаа.

2025 оноос эхлээд бид нар энэ ажлыг Монгол Улсын төсвийн хуульд оруулж өгсөн. Төсвийн хуульд 200 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх үүргийг 2025 онд бүрэн биелүүлж ажилласнаараа Төрийн албаны хуулийг хэрэгжүүлж ялангуяа төрд хохирол учруулж байгаа үйл ажиллагаанд хариуцлагын тогтолцоог тодорхой үр дүнтэй нэвтрүүлснийг харуулж байна аа.

Төрийн төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, ялангуяа Төрийн албаны зөвлөлийн гаргасан зарим тогтоолыг төрийн байгууллага албан тушаалтнууд хэрэгжүүлэхгүй, үл зөвшөөрч шүүхэд нэхэмжлэл гаргах хандлага ноднин байсаар байсан. Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу төрийн байгууллага, албан тушаалтан нь Төрийн албаны зөвлөлийн хуульд нийцүүлж гаргасан тогтоолыг заавал биелүүлэх үүрэгтэй. Энэ хүрээндээ шүүхийн холбогдох байгууллагууд өөрсдийнхөө хараат бус байдлаар энэ асуудлыг нэлээн сайн нарийн авч үзээд Төрийн албаны зөвлөлийн гаргасан баталсан шийдвэрээр нэхэмжлэл гомдол гаргах эрхгүй талаар Захиргааны хэргийн хэд хэдэн шүүхүүд шийдвэр гаргасан нь бид нар энэ хууль хэрэглээний зөв жишгийг тогтоож чадсан гэж үзэж байгаа.

Хууль бус томилгооны зөрчлийг бууруулах, маргааныг үнэн зөв, шуурхай, шударга шийдвэрлэх, ялангуяа төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг бүрэн цахимжуулах ажлыг 2025 оноос хийгээд эхэлсэн. Энэ ажил маань 2026 онд үргэлжилж хийгдэж байгаа. Ялангуяа шүүхийн шийдвэрийн болон хууль, хяналтын байгууллагуудтай систем хоорондын интеграц хийж ажиллаж байгаа нь бид нарын ажилд маш үр дүнгээ үзүүлж чадлаа гэж үзсэн.

Төрийн албаны нэгдмэл байдал, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ялангуяа үр дүн гаргах зорилгоор манай байгууллага 2025 онд нэлээн идэвх санаачилга гаргаж ажилласан. Бид Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг чанаржуулах, сайжруулах зорилгоор яам, агентлаг, аймаг НЗДТГ-ын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх журамд чадахуйн зарчмын хэрэгжилтийг хөндлөнгийн үнэлгээг манай байгууллага хийдэг байх талаар Засгийн газарт хүсэлт тавьж энийгээ албан ёсоор тогтоолоор баталгаажуулсан маань 2025 оны маш том үйл ажиллагааны нэг үр дүн байлаа гэж үзэж байна.

Энэ хөндлөнгийн үнэлгээг бид нар анх удаагаа 15 яам, 44 агентлаг, 22 засаг даргын Тамгын газрын ажлыг үнэлж үзлээ. Энэ үнэлгээг хамгийн гол нь жил бүр хийдэг ийм эрх зүйн орчныг бүрдүүлж чадсан нь магадгүй бид нарын ажлын үр дүнгийн нэгээхэн чухал хэсэг болох байх аа.

Өмнө нь Төрийн албаны зөвлөлөөс хүний нөөцийн аудитыг сэдэвчилсэн хэлбэрээр эсвэл цөөн тооны төрийн байгууллагуудыг түүврийн маягаар сонгож хийдэг байсан. Тэгвэл 2025 онд манай байгууллага энэ чадахуйн зарчмын хэрэгжилт буюу хүний нөөцийн аудитыг нийт 16 яамыг хамруулж хийлээ. 2024, 2025 оны үйл ажиллагааных нь дүнд ер нь энэ чадахуйн зарчмын хэрэгжилт ялангуяа иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж байгаа, томилж байгаа, чөлөөлж байгаа, ажлын гүйцэтгэлийг нь үнэлж байгаа, дэвшүүлж байгаа энэ бүх асуудлыг яг тухайн хүний мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлага болон ажлын үр дүнд нь тулгуурлаж хийж байна уу үгүй юу гэдэг дээр хянан шалгалт болон аудитыг хийлээ.

Аудитаар яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр тогтвортой, тогтворгүй жил бүр ингээд хийснээс болоод тухайн байгууллагын чиг үүрэг, ажлын байрны давхардал, хийдэлтэй үндсэн болон нийтлэг чиг үүргийн зохист харьцаа алдагдсан бүтцийн нэгжийн орон тоо оновчтой тогтоогдоогүй, хууль бус томилгоо хийгддэг, сул орон тоог хуульд заасан хугацаанд зарлан нөхөх ажиллагаа удаашралтай, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ бодитой бус шатлан дэвшихэд тэгш бус байдал үүсгэсэн байгаа зэрэг нь төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилт яамдуудын түвшинд хангалтгүй байна гэж дүгнэж, үүн дээрээ сайжруулах, хууль тогтоомжийн дагуу ажиллах чиглэлээр аудитын зөвлөмжийг гаргаж байгууллагуудад өгсөн.

Монгол Улсад энэ төрийн албаны хүний нөөцийн аудитыг олон улсын стандартын дагуу хийх ажлыг 2025 оноос нэлээн бататгаж эхэллээ. Энэнийхээ дагуу тодорхой ахиц гарч магадгүй. Бид нар өөрсдөө мөн суралцаж энэ чиглэлээр албан хаагчдаа мэргэшүүлэх, ялангуяа хүний нөөцийн аудитор бэлтгэх ажлыг бол эхлүүлж ажиллалаа.

Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлах эсэх зөвшөөрлийг манай байгууллагаас өгдөг. 2025 онд бид нар 91 төрийн захиргааны байгууллагуудаас энэ чиглэлийн хүсэлтийг авч хянаад 63 төрийн байгууллагын 7511 албан хаагчид хамаарах 2411 албан тушаалын тодорхойлолтыг 144 тогтоолоороо батлах зөвшөөрлийг олгосон байна.

2024 онтой харьцуулахад энэ албан тушаалын тодорхойлолтын батлах зөвшөөрөл хүссэн болон олгосон байдал маань 10 хувиар нэмэгдсэн. Энэ яагаад нэмэгдсэн бэ гэхээр нөгөө яам агентлаг болон аймаг НЗД-ын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн өөрчлөлтүүд давтамжтай хийгдсэнтэй холбогдуулаад

ажлын байрны нэршлүүд өөрчлөгдөх тохиолдлууд маш их гарсан. 2025 он бол албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон хамгийн тийм оргил жил байлаа. Албан тушаалын тодорхойлолтыг хэт ойрхон давтамжтайгаар өөрчлөх, ялангуяа тодорхой жишээ нь хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байхад шинээр албан тушаалыг бий болгох эрсдэлээс сэргийлж энийг иж бүрэн цахимжуулах ажлыг бол хийж эхэлсэн. Энэ маань эхнээсээ үр дүнтэй болж байна.

Нөгөө талаасаа бид нар ижил чиг үүрэг бүхий албан тушаалуудын тодорхойлолтыг нэгдмэл байдлаар батлах энэ зарчим руу орсноороо ажил маань тодорхой үр дүнтэй болж дахин дахин өөрчлөгдөөд байдаг явдал бол 2025 оны сүүлээр багаслаа. Засгийн газраас 4 жил тутам зохион байгуулагддаг энэ архив болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үзлэг гэж байдаг. Бид нар Засгийн газарт энэ талаар хүсэлт тавьж ер нь нийт төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалттай холбоотой шалгуур үзүүлэлт үнэлгээ үзлэгийг манай байгууллага манлайлж хийе гэдэг хүсэлт тавьж үүнийгээ Засгийн газрын тогтоолоор батлуулаад 40 үзүүлэлтээр нийт 150 төрийн байгууллагад үзлэг хийсэн үзлэг хийсэн. Энэ бол манай нөгөө хяналт шалгалтаас өөр. Энэ үзлэг хийснээрээ төрийн байгууллагууд ядахдаа ажлын байрныхаа зохион байгуулалтыг сайжруулах дотооддоо хэрэглэдэг бүх дүрэм журмаа шинэчилж цэгцлэх, хуульд нийцүүлэх, ялангуяа хүний нөөцийнхөө цахим болон цаасан хувийн хэргийн бүрдүүлэлтийг яг хууль журмын дагуу зохион байгуулах, үйл ажиллагааныхаа ажлын байрны орчин болон соёлыг бүрдүүлэхэд нэлээн ахиц гарсан ийм үйл ажиллагаа болж чадлаа.

Чадахуйн зарчмын хэрэгжилт, хүний нөөцийн аудит, хяналт шалгалт энэ үзлэг гэсэн энэ 4 гол чиг үүргийг хэрэгжүүлэхдээ байгууллагуудын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хуулийн дагуу хэрэгжүүлэх чиглэл дээр нь бид нар нэлээн анхаарал тавьж энэ чиглэлийн ажлыг зохион байгуулж ажилласан. Манай байгууллагын нэг чиг үүрэг төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх албан тушаалд шаардлага хангасан ялангуяа ур чадвартай, ёс зүйтэй, хариуцлагатай ийм иргэн албан тушаалтныг сонгон шалгаруулж томилуулах ёстой. Бид нар өнгөрсөн жил ерөнхий шалгалтыг 4 удаа улсын хэмжээнд зохион байгуулж нийт 4547 хүнийг нөөцөд бүртгэсэн 2025 онд. Жил болгон ер нь 4000-4500-ийн хооронд бид нар нөөцийн бүртгэл хийдэг.

2024 онтой харьцуулахад бүртгэлд хамрагдсан иргэдийн тоо 12 хувиар, шалгалтад оролцогчдын тоо 16.1 хувиар буурсан хэдий ч шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо 5 хувиар нэмэгдсэн. Энэ нь юу вэ гэхээр иргэд төрийн албанд орох хүсэл сонирхол их байна их байна. Ерөнхий шалгалтын үр дүнгээр жил болгон судалгаа хийж үздэг. Дүн шинжилгээ. Энэ судалгаагаар 35 хүртэлх насны залуучууд шалгалтад оролцогчдын 66.9 хувь, шалгалтад тэнцэж байгаа хүмүүсийн 63.5 хувийг эзлээд байгаа нь залуучууд залуус төрийн албанд ажиллах сонирхол хүсэл эрмэлзэл илүү байгааг мөн илэрхийлж байна.

2025 оны төгсгөлийн байдлаар ерөнхий шалгалтын нөөцийн 3 жил нь хүчинтэй байгаа 18156 иргэнээс 32.9 хувь буюу 5977 хүнийг л төрийн жинхэнэ албанд ажиллуулж чадлаа. Яагаад хувь ийм бага байгаад байгаа юм бэ? Өмнөх оноос энэ маань 3.4 хувиар буурсан. Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийгээд үзэхэд Засгийн газар, төрийн захиргааны байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг ойрхон ойрхон давтамжтай хийсэн ажлын байрууд солигдсон. Мөн эмч багшаас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах шийдвэр нөлөөлсөн гэж дүгнэсэн.

Төрийн албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд бид нар 2025 онд нийт 4960 сул ажлын байранд давтамжтай байдлаар 239 удаагийн тусгай шалгалт зохион байгуулсан. Энэ сул орон тоон дээр оны төгсгөлийн байдлаар 1999 хүн буюу сул орон тоо нөхөгдөж 2961 сул орон тоо нөхөгдөөгүй. Яагаад сул орон тоо нөхөгдөхгүй өмнөх онтойгоо харьцуулахад ингээд бууралт өсөлт байгаад байгаа юм бэ гээд үзэхээр энэний 61.4 хувь нь шалгалтад бүртгүүлэх хүсэлт ерөөсөө ирээгүй. 28.9 хувь нь бүртгүүлсэн хүмүүс нь Төрийн албаны хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагынхаа мэргэжил туршлага боловсролын шаардлагыг хангахгүй байна.

Тэгэхээр эндээс дүгнэлт хийгээд үзэхэд бидэнд тусгай шаардлага хангасан хүний нөөц бага байгаатай холбоотой юм болов уу гэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр бол дараа нь Засгийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаад явж байна.

Монгол Улсын хөгжлийн бодлого үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрийн албаны хууль болон хөгжлийн Засгийн газрын хөтөлбөр, авлигатай тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд төрийн албан хаагчид тавих энэ ёс зүй, мэдлэг чадварыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх, сонгон шалгаруулалтад цогц чадамжийн шалгуур нэвтрүүлэх замаар чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн төрийн албан хаагчийг ажиллуул гэсэн ийм үүрэг даалгаврууд өгөгдөөд байгаа.

Улс орны хөгжлийн стратегийн болон бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлдэг гол хүч нь төрийн албан хаагч. Тийм учраас бид нар энэ төрийн албан хаагчийн чадамжийг оновчтой тодорхойлох ялангуяа дээр дурдсан эрх зүйн бичиг баримтуудыг хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 онд нэлээн анхаарал хандуулж ажилласан. Дэлхийд буюу олон улсад төрийн албаны үр ашиг, хүний нөөцийн бодлого, инновац, ил тод байдал болон цахимжилтаараа тэргүүлдэг Финлянд, БНСУ, Канад, Япон, Сингапур, Герман, Эстони зэрэг улсуудын энэ төрийн албан хаагч нартаа тавьдаг чадамжийн хүрээний жишгийг судалж үзсэн. Мөн өөр орныхоо хууль тогтоомж болон Монгол Улсын төрийн албаны хөгжлийн онцлог, сургамж, туршлага, мөн хийсэн судалгаан дээрээ суурилоод төрийн албан хаагчийн чадамжийн хүрээг бүхэлд нь шинэчилж баталсан.

Чадамжийн хүрээг шинэчилж баталснаар бид нар албан тушаалд тавигдаж байгаа шаардлага болон сонгон шалгаруулалтын цогц хэлбэрүүдийг бүгдийг нь өөрчлөх, ялангуяа сургалт хөгжлийг нь төлөвлөхөд энийгээ бол илүүтэй түлхүү ашиглаж ажиллахаар энэ онд тодорхой ажлуудыг хийгээд явж байна аа. Төрийн албаны судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах ялангуяа төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэх Засгийн газартай хамтарч шинэчлэх нь манай байгууллагын нэг чиг үүрэг байдаг. 2019 оноос хойш хийгдсэн маш олон судалгааны ажлуудыг түүвэрлэж үзээд Удирдлагын академитай хамтраад яг одоо 21 гол судалгааны ажлыг [sudalгаа.mn](http://sudalгаа.mn)-д орууллаа. Ингэснээрээ төрөөс гарч байгаа төрийн албатай холбоотой бодлогын шийдвэрүүд судалгаанд суурилж хийгдэх, ялангуяа иргэн, төрийн албан хаагч нарт энэ хийсэн судалгааны ажлуудын үр дүн зөвлөгөө, зөвлөмжүүд бол нэлээн өргөн хүрээнд танилцагдах боломжийг олгосон. Энэний дараа бид нар 2025 онд зайлшгүй хийгдэх ёстой судалгаанууд юу вэ гэдэг дээрээ анализ хийж тодорхой төрлийн судалгаануудыг Удирдлагын академи болон ТББ холбогдох байгууллагуудад захиалга өгч гүйцэтгүүлсэн. Судалгааны ажлууд маань оны төгсгөлд хийгдсэн учраас яг энэ дээр 2025 ондоо

багтааж тодорхой үр дүнтэй ажлууд хийгдэж амжаагүй. Энийгээ тайланг нь ямар ч байсан Их Хурал, Засгийн газар холбогдох байгууллагууд руу хүргүүлээд ажиллаж байна. Төрийн албаны зөвлөл өөрөө судалгааны шинжилгээний ажлыг ингэж захиалж хийлгээд байхаасаа илүүтэй ер нь Монгол Улсын төрийн албан хаагч бүр өөрийнхөө эрхэлж байгаа ажил албан тушаалын чиглэлээр тодорхой хэмжээнд судалгаа шинжилгээний ажил хийдэг, дүн шинжилгээ хийдэг, асуудал шийдэл боловсруулах чадвартай байх ёстой гэж үзээд нийт Монгол Улсын төрийн албан хаагчдынхаа дунд бид нар төрийн албаны реформ буюу бидний шийдэл гэдэг ийм бүтээлийн уралдааныг зарлаж үзсэн.

Энэн дээр төрийн албан хаагчид маш идэвхтэй оролцсон, маш идэвхтэй оролцсон учраас бид нар энэ судалгааны ажлуудыг нь бусад төрийн албан хаагч нартаа таниулах, сургах ялангуяа мэдлэг хуваалцах ажлыг 2025 онд хийлээ. Төрийн албан хаагчийн сургалт хөгжлийн асуудлаар бол манай байгууллагын үндсэн чиг үүрэг нь Засгийн газартай хамтарч мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг баталдаг. Энэ хөтөлбөр 2019 онд батлагдсанаас хойш өнөөдөр болтол шинэчлэгдээгүй байгаа. Бид нар чадамжийн хүрээнээс гадна төрийн албанд ажиллаж байгаа 1561 хүн, нөгөө 330 сум, 9 тосгонд ажиллах үедээ 31827 хүнээс яг энэ сургалттай холбоотой асуудлаар санал асуулга авсан.

Энэн дээрээ суурилад ер нь 2019 онд батлагдсан энэ төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь шинэчлэх ажлыг Удирдлагын академитай хамтарч хэрэгжүүлээд сая өнгөрсөн 10 хоногийн өмнө Удирдлагын академиас хамгийн сүүлийнхээ төслийг хүлээж аваад байна. Энийг бид нар 2026 ондоо шинэчилж батлах ажлыг зохион байгуулна аа. Манай байгууллагын хамгийн чухал нэг ажил байдаг.

Монгол Улсын төрийн алба болон төрийн албан хаагчтай холбоотой улсын нэгдсэн тоо бүртгэлийг бид нар системээр хөтөлдөг. 2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 4330 төрийн байгууллагад 213611 төрийн албан хаагч ажиллаж байна. Энэ нь манай нийт хүн амын 6 хувь, ажиллах хүчний 14.5 хувийг эзэлж байна аа.

Төрийн албан хаагчдын маань тоо 2024 онтой харьцуулахад 13284 буюу 5.9 хувиар буурсан буурсан. Энэ маань нөгөө Улсын Их Хурлаас баталсан багш эмчээс бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулна гэдэгтэй бол нэлээн уялдсан ийм тоон мэдээлэл гарч байгаа.

Албан тушаалын төрлөөр нь авч үзэхэд нийт албан хаагчдын 7.6 хувь нь удирдах, 80.4 хувь нь гүйцэтгэх, 12 хувь нь туслах албан тушаалтан байгаа бөгөөд удирдах албан тушаалтан нь эрэгтэйчүүд, гүйцэтгэх албан тушаалтан нь эмэгтэйчүүд давамгайлж байгаа. Хүйсийн байдлыг нь аваад үзэхэд өнгөрсөн онтойгоо бараг ижилхэн. 64.3 хувь нь эмэгтэйчүүд, 35.7 хувь нь эрэгтэйчүүд. Бид нар энэ тоо бүртгэлийг хөтлөхдөө зөвхөн ингээд статистик тооноосоо илүүтэй төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөнийг давхар хөтөлж явдаг. Ер нь нийт хэдэн хүн гараад хэдэн хүн ороод энэ нь ямар нөхцөл байдлаас шалтгаалаад байгаа юм бэ гээд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх явцад 2025 онд нийт 27517 хүн төрийн албанаас гараад эргээд 14233 нь ажилд орсон. Үүний зөрөө түрүүний нөгөө хэлсэн бууралтын хувь байлаа. Ажлаас гарсан нийт хүмүүсийн 85.2 хувь нь төрийн үйлчилгээнийхэн, 10 хувь нь төрийн захиргааных, 3 хувь нь төрийн улс төрийнх, 1.8 нь төрийн тусгай албанд ажиллаж байгаа.

Дүн шинжилгээ хийгээд үзэхэд төрийн албанаас гарч байгаа хүмүүсийн хүмүүсийн дийлэнх нь 35 хүртэлх насныхан. 44.1 хувь нь 35 хүртэлх насныхан. Буцаад ажилд орж байгаа хүмүүсийн 28.4 нь энэ насныхан. Тэгэхээр бид нарын нөгөө залгамж холбоо төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилт дээр анхаарах цаг болсон юм болов уу гэж бодож байгаа.

Үүнээс дүн шинжилгээ хийгээд үзэхэд 2024 онд төрийн албан хаагчдын дундаж нас 38 байсан, 2025 оны дундаж нас 40 болсон. Тэгэхээр нэгхэн жилийн хугацаанд ингэж 1.5 функтээр нэмэгдэнэ гэдэг бол бид нар цаашдаа бодлогын түвшинд анхаарах ёстой болсныг харуулж байгаа юм аа. Төрийн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэлийг цахимаар хөтлөхөөс гадна 2025 онд хийсэн хамгийн том ажил юу байсан бэ гэвэл төрийн албан хаагчдад өөрсдөд нь зориулсан төрийн албаны порталыг бий болгож өгсөн. Энэ нь ямар учиртай юм бэ гэхээр төрийн албан хаагч хүн өөрийнхөө хувийн цахим портал руу нэвтрээд хувийн хэрэг болон бусад асуудлууд дээр хэрвээ алдаа мадаг байгаа тэрнийгээ залруулах засах боломжийг нь байгууллагуудад тавьж өгсөн. ингэснээрээ оны төгсгөл гэхэд 136 мянган хүн энэ портал сайт руугаа ороод өөрийнхөө цахим хувийн хэрэг болон холбогдох үйл ажиллагаатай юмнуудаа засаж чаджээ.

Дараагийн нэг гол асуудал бид нар энэ төрд байгаа мэдээллийг иргэнээс дахин дахин авахгүй байх гэдэг зарчмын хүрээнд И Монголиа болон тэр байгууллагатай хамтраад 3 төрлийн үйлчилгээг И Монголиа системд оруулсан. Энэ дээр 87 мянга гаруй хүн энэ үйлчилгээг авсан байгаа нь бид нарын үйл ажиллагаа үр дүнд хүрсэн юм байна гэж үзэж байгаа.

Дараагийн нэг гол ажил нь төрийн албаны нэгдсэн тоо бүртгэл болон холбогдох үйл ажиллагаагаар нэгдсэн ийм дашбоард байгаагүй. 2025 онд энийг хийж чадсан. Дашбоардыг ил тод нээлттэй болгосноороо хүссэн хүмүүс төрийн албатай холбоотой тоо бүртгэл болон нэгдсэн дүнг авах боломжийг нь нээгдсэн. Энэ тоон мэдээллийг төрийн бодлого шийдвэрт тусгах үйл ажиллагаа маань илүү сайжирна гэж бодож байгаа. Манай байгууллагын үндсэн үйл ажиллагаа бол хуралдаан байдаг. Бид нар энэ хуралдаанаараа 40 удаагийн хуралдаанаар одоо энэ тайлан танилцуулж байгаа маш товчхон танилцуулж байгаа энэ чиглэлээр асуудлуудыг хэлэлцэж нийт 593 тогтоол гаргаж, түүнийхээ хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна. 2025 онд Төрийн албаны зөвлөлийн гадаад харилцааг нэлээн эрчимжүүлэх чиглэлээр Канад болон Казахстан улстай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж мерит 2 төслийг нөхцөлийг эхлүүлсэн нь бид нарын нэлээн онцлох ажил байж чадлаа.

Төрийн албаны зөвлөл тайлангаа Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахдаа Төрийн албаны хууль тогтоомжийг хэрхэн сайжруулах вэ гэдэг саналыг заавал өгөх ёстой байдаг.

Бид нар 2023 онд нийт 17, 2024 онд.

**Б.Баярбаатар:** Цэдэвсүрэн дарга 10 минутад тайлан танилцуулах байсан. Би танд 25 минут өгөөд цаг дууслаа. 5 минут л сунгаж өглөө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйл. Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэх гэж заасан.

115.1-д Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан илтгэл мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ. 115.2.6. Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг ТББХ жил бүр 115.4 энэ хуулийн 115.2, 115.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох байнгын хороо гишүүдэд тараасан байна гэж заасан. Энэ дагуу тайлан буюу тоо бүртгэлийн тайлан гэсэн ийм ном цахимаар болон хэвлэлээр ингэж тараагдсан байж байгаа. Мөн тоо бүртгэлийн товчоо ийм брошюр тараагдсан байж байгаа. Ингээд Тамгын газрын дүн шинжилгээ мөн хуулийн дагуу хийгдэж тараагдсан байгаа.

Төрийн албаны зөвлөлийн тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Хэрлэн гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууна.

**Б.Баярбаатар:** Юуны өмнө Төрийн албаны зөвлөлийн тайлантай холбоотой өнгөрсөн жил төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тоон мэдээллийг илүү сайн гаргах ажлаасаа гарч байгаа нь гарч байна уу, өөр ажилд шилжиж байна уу ямар учир шалтгааны улмаас ямар албан хаагчид ямар төрлийн албан хаагчид яг хаана ажлаа сольж байна вэ, ажлаасаа халагдаж байна вэ гэдэг мэдээллийг гаргаач гэсэн хүсэлт гаргасны улмаас энэ жил ийм сайн тайлан гаргасанд бол талархалтай хандаж байна. Эхний ээлждээ бол яг энэ тайланг бүрэн гүйцэд уншаагүй байгаа учраас яг энэтэй холбоотой асуулт асуухгүй нь ээ. Гэхдээ ер нь бол бид тоо бүртгэл сайн байж байж эргээд нөгөө тоон дээр дээрээ ажиллаж байж сайн анализ дүгнэлтүүдийг хийж байж манай Монгол Улсын төрийн албан хаагчдын тогтворгүй байгаа нөхцөл байдал, энэ шилжилт хөдөлгөөн, учир шалтгааных нь гол учир шалтгааныг нь гаргаж чадах юм бол бид нар илүү сайн бодлогоо зангидах, илүү сайжруулах, төрийн албан хаагчдыг илүү тогтвортой ажиллуулах энэ боломж нь гарах юм уу гэж Статистикийн хорооны даргаар ажиллаж байсан хүний хувьд хэлмээр байна аа. Төрийн албаны зөвлөл 1 тийм шүдгүй арслантай л адил санагдаад байгаа юм. Төрийн албан хаагчийн эрх зүйн статусыг муутгаж байгаа, төрийн албан хаагчдыг ажлаас нь халж сольж байгаа хэлмэгдүүлж байгаа энэ асуудал бол Улсын Их Хурал шийддэгээсээ илүүтэй Засгийн газрын шийдвэрээр л явчихдаг шүү дээ. Сайд нар яам, Тамгын газар, агентлаг. Гэтэл Төрийн албаны зөвлөл маань өөрөө Улсын Их Хурлын харьяа байгууллага учраас Засгийн газрын үйл ажиллагаатай ердөөсөө уялдахгүй байгаад байна. Сайн уялдахгүй байгаад байна.

9 хувийн цомхотголыг Засгийн газраас оруулж ирсэн бодлогыг л Улсын Их Хурал баталж өгч байсан тухайн үедээ. Тэрнээс биш энэ бол Засгийн газрын өөрийнх нь санаачилга байж явсан. Улсын Их Хурлын гишүүд энийг санаачилж яваагүй. Тэгээд ердөөсөө л ийм механик 9 хувийн цомхотгол болчихсон. Хаана ямар хэрэгцээ шаардлага байна вэ хаана ямар албан тушаалын давхардал байна вэ гэдгийг ердөөсөө хараагүйгээр чиг үүргээс нь үл хамаарч ингээд 9 хувийг цомхотгосон нь маш олон хүнийг хохироосон, маш олон салбаруудын үйл ажиллагааг нь догдлуулсан ийм нөхцөл байдалд ажиглагдаж байна аа. Тэгэхээр энэн дээр Төрийн албаны зөвлөл ер нь цаашид хэрхэн яаж ажиллаж болох вэ гэдэг ийм 1 ерөнхий асуу асуулт байгаад байна. Сая өнгөрсөн хугацаанд буюу энэ 2025

онд болсон үйл явдлыг та хэд юу гэж дүгнэж байгаа вэ? Юунд илүү анхаарах боломжтой байсан бэ? Та нарт ямар мэдээлэл судалгаа уг нь бол байна вэ?

**Б.Баярбаатар:** Хариулах уу? Цэдэвсүрэн дарга хэддүгээр микрофон? Индрийн микрофон дээрээс харуулчих.

**Л.Цэдэвсүрэн:** Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлаас баталсан 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд багш эмчээс бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулна гэж байгаа. Бууруулна цомхотгол биш. Бид нар энэ асуудлыг тухайн үед нь бас тооцоо судалгааны асуудлууд нэлээн яригдсан хэдий ч мэдээж Засгийн газар энэ хууль хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийхэд нь ер нь бол нэлээн хамтарч ажилласан. Ялангуяа энэ дүн шинжилгээг манай статистик бүртгэлд яг яаж орж ирэх гэдэг дээр нэлээн дүн шинжилгээ хийж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Үндэсний аудитын газар болон хүний эрхийн комисстой яг төрийн албан хаагчийн эрх ашгийг хэтэрхий дордуулах ажиглал хийгдэх вий дээ гэдэг дээр болгоомжлолтойгоор хандаж ажилласан. жилийн эцсийн нэгдсэн тоо бүртгэлээ аваад үзэхэд түрүүний хэлдэг тэр 13 мянган бууралтын 718 хүн нь л бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн.

Хамгийн бид нарын хүлээгдээгүй бүүр гайхмаар зүйл юу байсан бэ гэхээр төрийн албан хаагч өөрийнхөө санаачилгаар 18 мянга гаруй хүн төрийн албанаас гараад явчихсан. Энэ 18 мянга зүгээр гараад явсан хүмүүсийн дийлэнх нь залуучууд байсан. Нолиос 10 жил ажиллаж байгаа 35 хүртэлх насны. Тэгээд энэ дээр мэдээж яах вэ 2025 оны нэгдсэн тоо гарсны дараа Засгийн газартай хэд хэдэн удаагийн уулзалт хийж, албан бичиг, саналууд явуулсан, албан бичиг саналууд. Тэгээд ер нь яг хамгийн сүүлдээ ямар дүгнэлтэд хүрээд байгаа юм бэ гэхээр Монгол Улсад төрийн албаны хүний нөөцийг бэлтгэх, сургах, хөгжүүлэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, үр дүнгийн гүйцэтгэлийг нь үнэлдэг ийм цогц бодлогын бичиг баримт бол өнөөдөр хүртэл байхгүй. Бид нар Алсын хараа-2050 дунд хугацааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ингээд үзэл баримтлал гэсэн ийм зүйлүүдээр энэ ажлаа ингээд багцлаад байгаа хэдий ч яг албан ёсны зүйлсүүд маань дутагдалтай байна гээд.

Дээрээс нь Засгийн газартай юу гэж хамтарсан нэг судалгаа хийсэн бэ гэхээр ер нь энэ чиг үүргийн шинжилгээг ялангуяа яам агентлагууд дээр ЗДТГ дээр хийгээд үзье гээд хамтарсан ажлын хэсэг гаргаад хийж үзсэн. Тэгээд чиг үүргийн шинжилгээний хүрээнд яг зөв бүтэц орж ирээд байна уу, үгүй юу, зөв ажлын байр гараад байна уу үгүй юу гэдгийг юугаараа дүгнэсэн юм бэ гэхээр манайд ирүүлж байгаа нөгөө албан тушаалын тодорхойлолтын хяналтаар авч үзсэн. Албан тушаалын тодорхойлолтын хяналт бол түрүүн миний хэлдгээр 10 хувь нэмэгдэнэ гэдэг бол бас чиг үүргийн шинжилгээ бодит байдал дээр сайн хийгдээгүй, дээрээс нь ажлын байрны нэршлүүд бас зөв тодорхойлогдоогүй. Түүнд тавигдаж байгаа шаардлагууд маань тодорхой хэмжээнд хууль тогтоомжид нийцээгүй байдлууд маш их гарсан учраас 91 байгууллагаас 63-ынх нь л албан тушаалын тодорхойлолтыг баталж өгч байгаа гэсэн үг.

Тэгээд өнөөдрийг хүртэл Засгийн газартай хамтраад дахиад чиг үүргийн шинжилгээнүүдийг яг нарийвчилж нэг бүрчлэн хийж байгаа. Тэгэхээр ингэж хийж байж л энэ цомхотгол гэж хэлэхээсээ илүүтэй 9 хувийн бууралтын асуудал дээр

төрийн албан хаагчийг хохироохгүй талаас нь ажиллахгүй бол болохгүй. Тэгээд яах вэ бид нарын яг хүлээгдээгүй саяын тайланд байгаа энэ ном дээр ч байгаа зүйлийг та хэд харвал бид нар яг үнэндээ төрийн албанаасаа залуу үеэ гаргаад байгаа юм билээ. Залуу үеэ гаргаад байна. Тэгэхээр энэ дээр төр тодорхой хэмжээний бодлого хөтөлбөртэй ажиллахгүй бол болохгүй юм байна гэсэн ийм дүгнэлтийг хийж байгаа.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүн тодруулна.

**А.Ариунзаяа:** Залуу үеэ буюу 18 мянган залуу төрийн албан хаагчид ажлаасаа гарсан байна гэдэг чинь төрдөө итгэхээ байсан ер нь залхсан байна гэсэн л үг шүү дээ. Тэгээд энэ юунаас болоод байгаа юм. Цалин хөлс цалингаа голоод байна уу, ажлын орчноо голоод байна уу, дарамттай байгаад байна уу? Учир шалтгаантай байх ёстой байхгүй юу. Энэ учир шалтгааныг нь бид нар гаргаж ирэх ёстой. Дарамттай танилын хүрээнд л явахгүй бол ажил явуулж болдоггүй гэсэн энэ ойлголт битүү тархаад байна шүү дээ. Тэгээд энэ бол манай Төрийн албаны зөвлөлийн хийх ёстой ажил мөн үү? Мөн.

Төрийн албаны зөвлөлөөс хууль бус шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор нийт 1 тэрбум 60 сая төгрөгийн үнийн дүн бүхий 59 мэдэгдлийг буруутай шийдвэр гаргасан иргэн албан тушаалтнаас гаргуулахаар өгсөн. Гэтэл 77.8 сая төгрөг л нөхөн төлөгдсөн байна гэсэн.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Төрийн албанаас гарсан гэдэг нь яг систем дээр одоо уг нь бид нарын төрөөс барьж байгаа энэ бодлого энэ шийдвэрүүд дээр системийн бүртгэл маань 9 хувийн бууралт нь арай өөр хэлбэртэй байх болов уу гэсэн, зүгээр төрийн албан хаагч өөрийнхөө санаачилгаар төрийн албанаас гарчихсан гэдэг нь дийлэнх байгаа 18 мянга. Хамгийн жоохон харамсалтай юм нь энэний 70.9 хувь нь эмэгтэйчүүд тэрэн дундаа гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа хүмүүс төрийн албанаас гараад явчихжээ. Саяын төрд учирсан хохирлын мэдээлэл бол биш байна. Ер нь нийлбэр дүнгээрээ энэ ажлыг 2020 оноос буюу яг идэвхтэй хэрэгжиж эхэлсэн нь 2023 оноос юм байна лээ. Бид нар 2024 онд 680 гаруй сая төгрөгийг буцааж төлүүлж байсан. 2025 онд уг нь хуулиар хүлээсэн үүрэг маань 200 сая байсан. Энийг 478 саяыг болгож төлүүлж чадсан чадсан.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүн тодруулчих тэгээд хариулъя.

**А.Ариунзаяа:** Яах вэ тодруулга нэг минутаар яваад байгаа учраас амжихгүй байгаад байна л даа. Яах вэ ямар ч байсан төрийн буруутай шийдвэр гаргасан хүн өөрөө эргээд энэ учруулсан хохирлоо төлүүлэх ёстой. Тэгэхээр энийг бол нөхөн төлүүлэх ажлыг ч гэсэн бид нар сайн хариуцлагатай нөхөн төлүүлэхгүй бол ер нь ямар ч хариуцлага байдаггүй мэтээр шийдвэр гаргаж байгаа хүмүүс дураараа аашилж дураараа хүмүүсийг хохироогоод байна уу даа. Тэгэхээр энийг бол бас хуулийн хэрэгжилтийг бид нар сайжруулах хэрэгтэй юм байна гэдгийг бол хэлмээр байгаа юм.

Хоёр дахь нь болохлоор хуулийн хэрэгжилт гэснээс энэ хуулиар хүлээсэн үүргээ төрийн алба өөрөө хариуцмаар байгаа байхгүй юу хиймээр байгаа юм. Тэгж байж бусдаасаа гүйцэтгэлийг нэхнэ.

Нэгдүгээрт би хэлэх гээд байгаа хуулиуд юу вэ гэхээр Жендерийн тухай хууль. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулах тухай хууль, Ахмад настны хөдөлмөрийг дэмжих тухай хууль. Тэгээд төр өөрөө энэ хуулиудаа хэрэгжүүлэхгүй бол хэн хэрэгжүүлэх юм бэ?

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Тийм төрд учруулсан хохирол дээр яах вэ гишүүний тоог хаанаас харж байгааг би сайн мэдсэнгүй. Ямар ч байсан бид нар 2025 онд 478 сая гэдэг бол бид нарын хувьд их мөнгө байлаа. Энийг хийхэд хууль хяналтын байгууллагатай нэлээн сайн хамтарч ажилласан, шүүхэд нэхэмжлэлүүд гаргаж ажилласан. Тэгээд энийгээ ч гэсэн ер нь цааш нь илүү идэвхтэй үргэлжлүүлж явна гэж бодож байгаа. Энийгээ цахим систем рүү оруулчихсан учраас төрийн албан ялангуяа удирдах ажилтнууд бол энэ талын мэдлэг мэдээлэл нь сайжирч, ялангуяа төрийн албан хаагчийг хохироох шийдвэр гаргалт нь багассан.

**Б.Баярбаатар:** Энхтуяа гишүүн асуултаа асуучихъя. Гантөмөр гишүүнийг Энхтуяа гишүүний дараа дараалалд оруулчаарай.

**Д.Энхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Саяхан Улсын Их Хурлаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтөөр бол аймаг, дүүрэг, сум НИТХ-ын төлөөлөгчдийн 50 хувь нь төрийн жинхэнэ албан хаагч байж болно оо гэсэн ийм зохицуулалт анх орж ирээд тэгээд хууль батлагдахдаа бол 30 хувь нь байж болно оо гэж ингээд батлагдсан байгаа. Тэгэхээр энэ дээр бол миний хувьд бол тухайн үед үзэл бодлоо илэрхийлж байсан. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд шууд халдсан ийм үйлдэл боллоо гэсэн ийм тайлбарыг саналыг өгч байсан. Тэгээд энэ хууль батлагдсан байгаа.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл энэ саяын батлагдсан энэ хуульд ямар үзэл баримтлалтай хариулт өгөх вэ? Энэ үнэхээр нөгөө нутгийн нутгийн иргэд чинь ИТХ-аараа дамжуулж иргэд маань үйл ажиллагаагаа төрөө удирддаг тиймээ, хяналт тавьдаг ийм систем л дээ. Гэтэл энэ системийг ингээд нураачхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол бас Үндсэн хуулийн маргааныг дагуулж ч магадгүй ийм зөрчил харагдаж байна.

Хоёрт гэвэл төрийн жинхэнэ албан хаагч бол төрийн ажлаа л хийгээд явдаг. Иргэдийн Хурлын Төлөөлөгч бол иргэдээсээ сонгогдож төрдөө хяналт тавьдаг ийм л механизм шүү дээ. Тэгэхээр энэ механизмыг өөрчилсөн ийм хууль батлагдчихлаа л даа. Тэгэхээр энэ дээр Төрийн албаны зөвлөл ямар бодлоготой ямар зарчимтай энд хандсан бэ? Та бүхнээс ямар нэг байдлаар энэ дээр санал асуулга орсон уу? Ямар нэгэн хууль ч батлагдахдаа Засгийн газраар орж энэ хуралдааны тэмдэглэл байдаг. Засгийн газар дэмжсэн дэмжээгүй саналаа өгдөг. Тэгэхээр та бүхэнд энэ санал очсон уу?

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Энхтуяа гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэгт энэ Төрийн албаны хуульд өмнө нь Монгол Улсын засаглал болон хүний нөөц бодлого хөтөлбөртэй холбоотой

асуудлаар санал авна гэдэг зүйл байсан нь 2020 он 2 оны 7 сард хүчингүй болчихсон юм. Одоо ганцхан манайхаас юугаар санал авч байна гэхээр төрийн албан хаагчийн цалин хөлстэй холбоотой асуудлаар л санал авдаг. Энийг бид нар 2025 онд Их Хурлын гишүүдтэйгээ хамтраад Төрийн албаны хуулийн энэ асуудлыг цэгцэлж байлаа. Бид нар энэ төрийн албаны хяналт шалгалтыг хийхдээ Төрийн албаны хуульд байгаа улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам эвслийн үйл ажиллагаанаас ангид байх гэдэг зарчмаа л барьж байгаа. Өмнө нь Амгаланбаатар гишүүн бас яг ийм чиглэлийн хууль санаачлахдаа яг гишүүнийхээ хувьд манайхаас санал авсан. Бид нар яг энэ байр сууриа илэрхийлсэн. Энийг бол дэмжихгүй ээ. Яагаад гэхээр хууль ийм байгаа. Нэг нь сонгогддог албан тушаал, нөгөөдөх нь Төрийн албаны хуульд заасан маш олон шаардлагуудыг хангаж томилогддог албан тушаал. Энэ 2 хоорондоо нийцэл болохгүй гэж тухайн үедээ гишүүнд албан ёсоор санал өгч байсан. Сүүлийн саяын батлагддаг улс төрийн шийдвэрийн хувьд бол албан ёсоор санал аваагүй ч гэсэн бид нар тухайн үедээ Байнгын хорооны дарга болон хууль санаачлагч нартаа энэ зарчмаа тайлбарлаж холбогдох мэдээллүүдийг өгч байсан. Тэгээд нэгэнт улс төрийн шийдвэр гарчихлаа. Гэхдээ манай байгууллага хянан шалгалт хийх явцдаа яг энэ чиглэлийн асуудлаар тогтоол гаргадаг. Нөгөө хүнд нь сонголтыг нь өгдөг. Та нэг бол төрийн захиргааны албан хаагчаа л хий. Эсвэл улс төрөө хөө. Аль нэг сонголтгоо хий гэдэг энэ зарчим дээрээ бид нар хэвээрээ л байна гэж бодож байгаа.

**Б.Баярбаатар:** Энхтуяа гишүүн тодруулъя.

**Д.Энхтуяа:** Тэгэхээр төрийн албаны хуулиар бол төрийн алба бол улс төрөөс ангид байх ёстой. Энэ бол хамгийн анхны зарчим шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ дээр бол улс төржилт маш их явагдана, ашиг сонирхлын зөрчил их гарна тиймээ. Тэгэхээр энэ хууль бас батлагдсан өдрөөсөө хэрэгжиж эхэлж байгаа. Тэгэхээр хаана улс төржилт их явагдаж энэ төрийн алба гацдаг вэ гэвэл ер нь орон нутагт, дүүрэг дээр, аймаг дээр, нийслэл дээр ч гэсэн өчигдөр та бүхэн харж байгаа тиймээ. Нийслэлийн иргэдийн хурлын 45 төлөөлөгч 45-уулаа Засаг даргаа хянаж чадахгүй бүгдээрээ Засаг даргынхаа доор ороод төрийн албаны орон нутгийн өмчит компаниудын захирал хийгээд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ улсын ажил чинь яг энэ төрийн алба гэдгээр явж чадахгүй хэтэрхий их улс төржилт явагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хууль батлагдаад яг ингээд батлагдсан өдрөөсөө хэрэгжиж эхлэхээр та бүхний ажилд бол маш их саад бэрхшээл учирна гэж бодож байна. Тэгэхээр энийг та бүхэн та цаашид яаж засаж залруулах юм, ямар арга хэмжээ авах юм, яаж ажиллах юм, энэ дээр ямар бодлого баримтлах юм.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Түрүүн хэлснээр бид нар Төрийн албаны хуулийнхаа зарчмаа л барина, зарчмаа л барьж ажиллана. Сонгогддог, томилогддог 2 өөр албан тушаал нэг дор байх нь ерөнхийдөө энэ Төрийн албаны хуулийн түрүүний хэлдэг улс төрийн албан хаагчаас бусад хүмүүс, албан тушаалтан нар, төрийн албан хаагч нам, улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх гэдэг зарчмыг барина аа. Хяналт шалгалтын явцад бас яг саяын хэлснийгээ л танд дахиж хэлмээр байна. Бид нар хяналт шалгалт хийхэд энэ асуудал зөндөө гарч ирнэ. Гарч ирэх нь тодорхой. Өмнө нь ч гарч байсан юм. Ялангуяа аймгууд дээр их гардаг байсан.

Тэгээд аймгууд дээр гарахдаа бол тогтоол гаргаад тэр хүнд тодорхой хугацаа өгөөд сонголтыг нь хийлгэдэг байсан юм. Нэг бол та тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчийнхаа ажлыг хий, эсвэл та тэрнээсээ бүрмөсөн татгалзаад улс төрийн албан тушаалаа хаш гээд. Тэгээд бид нар яг 2025 онд үүнийг цэгцлээд дуусаад хамгийн сүүлд Увс аймгийн нэг иргэдийн төлөөлөгч хүн өөрөө төрийн захиргааны албаа хашъя гээд ингээд.

**Б.Баярбаатар:** Тодруулах уу? Болсон уу? Энхтуяа гишүүн тодруулга.

**Д.Энхтуяа:** Яах вэ ер нь бол яах вэ эрх баригч нам сүүлийн 10 жил эрх барьж байна. Тэгэхээр хөдөө орон нутагт бас төрийн албан хаагч нар хомсодсон гэдэг ийм тайлбарыг хэлэх байх. Гэхдээ төрийн албан хаагчдыг хөдөө орон нутагт ажиллуулах тэр нөхцөл бололцоог нь сайжруулах тэр бүх бодлогыг явуулах ийм боломж байсан. Харамсалтай нь тэгж чадсангүй. Тэрийгээ бол ингээд төрийн албан хаагч хомсдож байна гэдгээр ингэж байгаа. Гэхдээ Төрийн албаны зөвлөлийн хувьд бол энэ маш их зөрчил дутагдлыг авчрах ийм л хууль болчихлоо. Тэгэхээр та бүхэн Төрийн албаныхаа хуулийг баримталж ажиллана гэж байна. Энэ хууль чинь хуулиас чинь дээр хууль гарчхаад байна шүү дээ. Тэгэхээр ер нь улс төржилт явагдах нь тодорхой. Улс төрчид чинь тэр төрийн албан хаагчийн албан тушаал дээр томилогдоод оччихоод байна шүү дээ. Сонгогдчихоод дахиад томилогдоод байгаа байхгүй юу. Тэрийг нь холион бантангийн л зүйл болоод байна л даа.

**Б.Баярбаатар:** Үг хэлчихлээ.

Лувсанн्याмын Гантөмөр гишүүн асуултаа асууя.

**Л.Гантөмөр:** Төрийн албаны зөвлөлийн тайланг гүйлгэж харлаа мэдээлэл сонслоо. Ажил их хийсэн байна. Хамгийн гол нь үр дүн юу байв гэж. Төрийн албаны үнэлэмж дээшилсэн үү? Үйлчилгээний хүртээмж сайжрав уу? Хүний хөгжлийн индекс урагшлав уу? Төрийн албаны чанар чансааг яг юугаар үнэлэх юм бэ гэдэг ийм асуулт байгаа. Энэ дээр манай Төрийн албаны зөвлөлийнхөн маш тодорхой хариулах хэрэгтэй. Загас толгойноосоо өтдөг. Яг энэ яам, тамга, агентлаг удирдаж байгаа хүмүүсийн чанар чансаа хэр байгаа вэ? Энэ дээр их бодитой хариулт өгмөөр байна. Энэ улсууд маань яг мерит зарчмаараа томилогдож байгаа юу гэдэг дээр маш тодорхой хариулт өгмөөр байна.

Жишээлбэл гааль, татвар, даатгал, ер нь ялангуяа ЭМД-ын газар гэх мэтчилэн хөрөнгө мөнгө их зарцуулдаг улс төрчид их очиж нөлөөлдөг. Энэ төрийн байгууллагуудын ур чадвар буюу мерит зарчим 2 хэр зэрэг харьцаагаа барьж хийгдсэн бэ? Эхний асуулт бол энэ байна.

Хоёр дахь асуудал та бүхэн бол одоо ингээд харахаар нэг тийм хяналтын алба шиг харагдаад байна. Би бол илүү хөгжлийн байгууллага байгаасай гэж анх энэ төрийн албыг бол бид нар төрийн албаа сайжруулахын төлөө байгуулсан юм л даа. Тэгээд одоо яг хэдэн онд юу ярьж байгаагаа бүгдээрээ нэг сайн бодооч, хараач. Тэр хүний хөгжлийн асуудал дээр Төрийн албаны зөвлөл бол онцгой үүрэгтэй байх хэрэгтэй.

Ялангуяа одоо энэ Удирдлагын академи гэдэг байгууллагыг та нар өөрийнхөө харьяанд авах хэрэгтэй. Та нар Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчид буюу төрийн удирдах албыг бэлддэг газрынхаа сургалтын хөтөлбөрийг захиалахгүй

болохоор улс төржсөн хүмүүс тэндээс гарч ирээд байна, намын харьяалалд бүрэн орж байна. Яагаад гэвэл Засгийн газрын мэдэлд байдаг учраас Засгийн газар бүх томилгоо, бүх хөтөлбөр юман дээр нь анхаарлаа тавьдаг. Ингэснээрээ бол ийм байдал үүсэж байна. Тэгээд эцэст нь бол төрийн үйлчилгээ гэдэг бол сэтгэлийн юм шүү дээ. Хүний тухай ойлголт. Яагаад Монголчууд төрийн албанд сэтгэл дундуур байгаад байгаа вэ гэхлээр хүн биш болчихсон. Дарга гэдэг сэтэртэй, тусгай алба гэдэг ийм статустай. Хүндээ үйлчилж чадахаа байчихсан. Хүнтэй мэнд усаа мэдэж чадахаа байчихсан, хүнтэй хүнлэг байдлаар харьцаж чадахаа байчихсан.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа мэдээж төрийн албаны хуульд заасныхаа дагуу хэрэгжээд явж байгаа. Бид нар энэ хүний хөгжлийн индекс Монгол Улсын холбогдох бусад хөгжлийн индексүүдээсээ илүүтэй 2024 онд энэ улс, олон улсад төрийн албаны олон улсын индекс гэж байдаг юм байна лээ гаргадаг. Ингэж үнэлдэг улс орнуудыг. Энэ индексийг яаж гаргадаг юм бэ гэдгийг нэлээн судалж байгаад АНУ-д төв нь байдаг байгууллагатай холбогдоод Монгол Улсыг эхний ээлжид 2024 онд туршилтын байдлаар оруулаад өгөөч гэдэг хүсэлт тавиад өөрсдийгөө ер нь хаана явж байгаа юм бол оо гэдэг үнэлгээг хийлгэж үзсэн. Олон улсын индекс нь. Тэгээд нийт 180 гаруй улсаас манайх 56-д эрэмбэлэгдсэн нэг тийм эхний үнэлгээг бид нарт гаргаж өгсөн. Одоо 2 дахийг нь энэ оны 9 сард гаргаж өгөх юм. Энэ бүүр хөндлөнгийн үнэлгээ хийдэг юм байна лээ. Хэн нэгэн Монгол Улсын аль нэгэн байгууллагаас тайлан мэдээлэл авдаггүй манайхаас ч авдаггүй.

Тэгэхээр энэ үнэлгээг яагаад хийлгэсэн юм бэ гэхээр энэ нөгөө засаглалын үзүүлэлт, нөгөө хүний хөгжлийн үзүүлэлт, нөгөө авлигын индекс эд нартай хэрхэн яаж уялддаг юм бол оо гэдгийг нэлээн сайн судалж байгаа.

Хоёрт нь түрүүний маш товчхон танилцуулдаг чадамжийн хүрээ гэдэг зүйл байгаа. Энийг яагаад ингээд чадамжийн хүрээг та нар онцлоод байгаа юм бэ гэхээр ер нь Монгол Улсын төрийн албанд, ялангуяа захиргааны албанд тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэл дээр яг ямар хүн ажиллах ёстой юм бэ ямар чадамжтай хүн байх ёстой юм бэ гэдгийг бид нар түрүүний хэлдэг 10 улсын туршлагыг судлаад өөрөө орныхоо онцлогт тохируулсан энэ хүрээг гаргаж ирсэн. Энэнийхээ эхний оношилгоог энэ онд хийсэн. Энэ 2025 оны ажил биш байсан учраас би хэлсэнгүй. Төрийн захиргааны 19 мянган албан хаагчдыг бид нар та яг ямар чадвартай хүн бэ гэдэг оношилгоог хийж үзсэн. Асуудал байна, зөндөө асуудал байна. Энийгээ чадавхжуулах, сайжруулах ажлуудыг зохион байгуулж байгаа. Меритийн зарчмаар яам агентлагт хүн томилогдоод байна уу гэж асууж байна. Түрүүний тайланд хэлсэн одоо энэ тайлангийн ном дээр байгаа зарим тохиолдолд үнэндээ меритийн зарчмаар томилогдож чадахгүй байна. Тэгэхээр энэ дээр бол бас Засгийн газар болон яамдууд руу нь холбогдох бүх зөвлөгөө зөвлөмжүүдийг өгөөд л ажиллаж байгаа.

2025 оноос эхлээд бид нар энэ хяналт шалгалт гэдгийг хяналт шалгалт зөрчил илрүүлж заавал тэгж буруутгахаасаа илүүтэй гарахаас нь өмнө сэргийлэх, дээрээс нь төрийн албан хаагчдыг өөрсдийг нь ажлын байран дээр болон бусад хэлбэрээр сургах ажил дээр нэлээн анхаарал хандуулж байгаа. Энэ манай үндсэн чиг үүргийн ажил биш хэдий ч бид нар төрийн албан хаагчдыг өөрсдийг нь хөгжүүлэхгүй юм бол цаашдаа яг ийм тогтсон ингээд нэг ийм байдлаасаа цаашаа ахих боломж байхгүй юм байна гэдэг ийм судалгаа хийсэн юм. Тэгээд энэн дээрээ

суурилоод энэ төрийн албан хаагчийн мэргэших сургалт болон ажлын байрны сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь шинэчилж байна. Энийг бид нар өөрсдөө манлайлоод Удирдлагын академийг оролцуулоод хийж байгаа. Нөгөө талаасаа бид нар хяналт шалгалт гэдгээсээ илүүтэй хамгийн эхний ээлжид юуг авч байгаа вэ гэхээр одоогийн ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа сургалт хөгжил, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажлыг нэлээн түлхүү хийж байна. Ингэж байж энэ хуулийн хэрэгжилтийг зөв талд нь гаргаж ирэхгүй бол зүгээр хянаж, шалгаж байна та нарын тэрийг хүчингүй болгоно. Та нар ийм алдаа гаргалаа гээд байдгаасаа илүүтэй зөвлөх хууль хэрэгжүүлэх тал дээр нь туслалцаа үзүүлэх чиг үүргийн шинжилгээг зөв хийх тал дээр нь ажиллахгүй бол бид нарын энэ ажил цаашаагаа явахгүй юм байна гэж бодсон.

Нөгөө талдаа төрийн албан хаагч нартай уулзсан болон маш олон удаагийн судалгаанаас нэг зүйл ажиглагдсан. Төрийн албаны энэ эрүүл ахуй, ажлын байрны дарамт, ялангуяа энэ чиглэлээр төрөөс тодорхой арга хэмжээ аваач гэдэг саналыг тэр хөдөө орон нутагт ажиллаж байгаа 110 гаран мянган хүн албан хаагч нар ер нь төрийн албан хаагч нар тийм саналууд маш их гаргасан. Энэн дээр суурилоод бид нар сая Их Хурлаас баталсан 5 жилийн үндсэн чиглэлд.

**Б.Баярбаатар:** Тодруулах уу? Гантөмөр гишүүн. Хариултаа дуусгачих индрийн микрофон нэг минут.

**Л.Цэдэвсүрэн:** Энэн дээр суурилоод ер нь хууль байвал байна хэрэгжилт нь явж байна уу явж байна. Тэгвэл өнөөдөр бид нар төрийн албан хаагчийгаа өөрийг нь дэмжих чиглэлийн юм хийхгүй бол ажлын байрны сэтгэл зүйн дарамт болон ажлын байрны бусад дарамтын асуудал бол Монголд энэ төрийн албан хаагчдаас өөрсдөөс нь авсан судалгаагаар маш өндөр гараад байна. Тийм учраас энэ олон улсын жишгүүдийг судлаад энэ ажлын байрны сэтгэл зүйн болон ажлын байрны ялгаварлан гадуурхалтын чиглэлийн ийм стандартууд байдаг юм байна олон улсад. Энийг Монголд нутагшуулах чиглэлийн ажлыг энэ оноос судлаад явж байна. Энийгээ бид нар энэ 2026 ондоо багтааж хийнэ гэж бодож төлөвлөж байгаа. Ингэснээрээ нэлээн үр дүн гарах болов уу гэсэн ийм найдлагатай ажиллаж байгаа

**Б.Баярбаатар:** Гантөмөр гишүүн тодруулъя.

**Л.Гантөмөр:** Би тэр нөгөө сургалтын хөтөлбөр буюу сургалтын байгууллага дээрээ та бүхний оролцоог нэмэгдүүлэх тухайд та нарын идэвх санаачилга бол аймаар чухал байна аа. Яагаад гэвэл та нар бол Төрийн албаны зөвлөлийнхөн гэдэг чинь аль нэг намын өнөөдөр та нар аль нэг намын харьяанд бүртгэлтэй хүмүүс биш шүү дээ. Тиймээ буцаад мэдээж намынхаа харьяалал сэргээвэл ихэнх нь МАН-д л очих байх л даа. Тэгэхдээ тэгж бодолгүйгээр яг энэ төрийн албыг хөгжүүлж, төрийн албан хаагчийн хөгжлийн асуудал.

Хөгжлийн асуудал гэхээр бид нар мэдээж чадамж дээрээ суурилоод явна. Нөгөө талдаа хүн байх тухай. Үйлчилгээний албанд ажилладаг хүмүүсийн тэр хүн байх тухай сургалтын хөтөлбөрүүд гэдэг зүйлийг онцгой хийхгүй болохоор тэнд чинь тийм хүний хохирол бий болоод байгаа байхгүй юу. Ард түмэн хохирдог дээр нь албан хаагч хохирдог. Дарга цэрэг нь нэг тийм диаграм маягтай.

**Б.Баярбаатар:** Цэдэвсүрэн дарга. Индрийн микрофон хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Сургалтын агуулга хөтөлбөрийг яагаад ингээд 2019 оны өнөөдөр хүртэл батлагдчихсан хөтөлбөрийг шинэчлэх гээд байгаа юм бэ гэхээр түрүүн хэлсэн бид нар нэг 30 гаруй мянган төрийн албан хаагчдаас яг энэ сургалтын чиглэлээр нь асуулга авч үзсэн юм. Тэрэн дээр юу гарч ирж байна гэхээр одоогийн байгаа Удирдлагын академийн хийж байгаа энэ урт богино хугацааны сургалтын тоо боломж нь хангалттай биш байна. Агуулга нь өнөөдрийн бид нарын бодит хэрэгцээг хангахгүй байна. Ажлын байран дээрээ бид нар илүүтэй суралцмаар байна. Яг энэнтэй холбоотой төсөв санхүүгийн асуудал хүндрэлтэй байна ч гэдэг юм уу ингээд ийм олон асуудлууд үүссэн. Ганцхан судалгаан дээр суурилагагүй ер нь төрийн албан хаагчийг өөрийг нь мэргэшүүлэх, сургах, дэмжих чиглэлээр ажиллах ёстой юм байна гэдэг агуулгаар нь энэ хөтөлбөрийг бүхэлд нь өөрчилж байгаа.

Өөрчилнө өө гэдэг нь зүгээр хууль хэрэгжүүл, хууль чи заавал энийг сур гэдгээсээ илүүтэй хөтөлбөрийн маань одоогийн байдлаар төслийн бараг нэг 40-өөд хувь нь софт скиллийн чиглэлийн сургалтын агуулгууд явж байна. Тэгээд төрийн албан хаагчдыг заавал нэг газар танхимаар сургахаасаа.

**Б.Баярбаатар:** Гантөмөр гишүүн сүүлийн тодруулга.

**Л.Гантөмөр:** Түрүүн тэр Ариунзаяа гишүүний асуугаад байсан тэр залуучууд яагаад төрийн албанаас дайжаад байна гэдэг асуултад бид нар заавал хариулах хэрэгтэй байна. Нэг үгээр хэлбэл тэр улсуудын цаашаага өөрийгөө хөгжүүлэх энэ албан дээр би хөгжихгүй байна гэдэг нэг ийм юм байгаад байгаа байхгүй юу. Бодит байдал дээр би хөгжихгүй байна. Нөгөө талдаа бол яам, Тамгын газар ажиллаж байгаа залуучууд чинь сургуульд сурмаар байдаг байхгүй юу. Гэтэл тэр магистрын сургалт гэдэг юм нь байна уу, тэтгэлэг өгөх юм уу. Одоо бараг төрд ажиллаад бид нар чинь 1990 онд хүнгүй болчихсон болохоороо сургана шүү. Та нарыг гадаадад сургана, төрд ажилла гээд урьсаар байгаад нэг хэсэг хүнээ сургаад авсан шүү дээ. Гэтэл одоо болохоор сургахгүй. Тэгээд яг төрд энэ залуу хүмүүс ажиллахаар давуу тал юу юм, юу байгаа юм гэдэг ийм зүйл байгаа байхгүй юу. Гэх мэтчилэн та нарын судалгаа шинжилгээгээр зөндөө юм гарч ирж байгаа.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Тийм. Яах вэ заавал индэр дээр гараад микэнд хэлэхээсээ илүүтэй бид нар яг энэ 2025 оны тайлан болон нэгдсэн тоо бүртгэл дээрээ түрүүн Ариунзаяа гишүүний хэлснээр нэлээн сайн дүн шинжилгээ хийсэн. Тэгээд яг бид нарын хүлээгээгүй үр дүн гараад ирчихсэнийг түрүүн хэлсэн. Бид нар ерөөсөө залуу үеийг ингэж төрийн албанаас их гарч байгаа тэрэн дундаа эмэгтэйчүүд давамгай гарч байгаа, тэрэн дундаа бүүр гүйцэтгэх албан тушаалынх нь давуу гарч байгааг яг энэ хамгийн сүүлийн тоон мэдээ статистикаасаа дүн шинжилгээ хийгээд үзсэн юм л даа. Тэгээд энэ дээр тодорхой санал саналуудаа Засгийн газар өнөөдөр Байнгын хороондоо хэлж байна. Их Хурлын даргатай уулзахдаа хүртэл хэлсэн. Бид нар энэ дээр нэгдсэн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй л бол энэ цаашдаа нэлээн эрсдэл үүсэх хандлагатай болчихжээ гээд. Нөгөө талаасаа манай байгууллагын нэг чиг үүрэг байгаа. Бид нар төрийн албан дахь жендерийн төлөв байдал ажлын байрны ялгаварлан гадуурхах бэлгийн дарамтын асуудлаар судалгаа хийж энэ тайлангаа Улсын Их Хуралд танилцуулах ёстой.

**Б.Баярбаатар:** Зулпхар гишүүн асуултаа асууя.

**С.Зулпхар:** Байнгын хорооны даргалагч болон гишүүд, Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Тодорхой асуултууд тавья. Энэ төрийн албан хаагчдын тоо чанарын асуудал байнга л яригддаг л даа. Нэг бол тоо нь их байна гээд л багасга гээд л. Нэг бол чанар нь болохгүй байна чанарыг нь сайжруул гээд л. Ингээд л ийм асуудал яригддаг. Нэг бол бид огт энэ талаар ямар нэгэн үзэл баримтлал өөрийн гэсэн бодлогогүй юм шиг ийм л зүйл яригдаад байгаа юм л даа. Тэгээд яг энэ тоотой холбоотой, чанартай холбоотой Төрийн албаны зөвлөлийн өөрийнх нь баримталж байгаа бодлого чиглэлийг та бүхэн сая Гантөмөр дарга тодорхой зүйлийг яриад байгаа гэсэн шүү дээ. Та бас энэ талаар өөрийнхөө байр суурийг гишүүдийн байр суурийг нийтлэг байдлаар илэрхийлж өгөөч гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёр дахь зүйл. Өнгөрсөн хугацаанд бид нэг ийм системийн дахин инженерчлэл гээд л байгууллагуудаар хийлээ л дээ. Тэрнээс өмнө чиг үүргийн шинжилгээ ажлын байрны шинжилгээ хийгээд л болоод л байдаг байсан. Тэгээд энэ шинэ бидэнд туршлага нэвтэрлээ. Тэгээд цаашдаа энэ системийн дахин инженерчлэлийг бид бүх байгууллагууд хийж амжих юм уу? Эсвэл бидэнд ашиглаад сурчихсан нөгөө аргуудаар хийгээд байгууллагуудын бүтэц чиг үүргийг бүтэц, зохион байгуулалтыг хүний нөөцийн жишээ нь чадавхыг тодорхойлох боломжтой юу? Энэ дээр та бүхэн судалгаан дээр тодорхой зүйл бичсэн байна лээ. Би энийг бүүр зориуд асууя гэж байгаа юм.

Гурав дахь зүйл бол сая нөгөө төрийн албан хаагчтай би чинь нэг ингээд 9 хувийг нь ч чөлөөлнө гэхээд яг тэрэнд хүрээгүй 5 гаран хувьтай л байгаа юм байна л даа.

Тэгэхээр энэ явцад та бүхэнд их гомдол ирж байгаа байх аа. Нэн ялангуяа Засаг дарга нар өөрсдөө бас өөрөө бүтцийг нь тодорхойлдог тийм захирамж гаргачихдаг байгууллагууд дээр жишгээсээ давсан ийм асуудлууд гараад байгаа юм. Нэг аймагт 18 хүнтэй бүтэцтэй байхад нөгөө аймагт 6 болгоод хаячихсан ийм зүйл байна л даа. Энэ гомдлууд дээр та бүхний жишээ нь байр суурь эс үгүй бол та бүхэн энэ дээр ямар чиглэл өгч байгаа вэ? Тэгээд л тэр чигт нь орхичоод юм уу эс үгүй бол шүүх дээр оч гээд л хаячхаж байна уу? Нэг бол та бүхэн жишээ нь энэ дээр ямар нэгэн байдлаар арга хэмжээ авах боломжтой байна уу?

Дараагийн асуулт бол энэ төрийн албаны талаарх иргэдийн санаа бодлыг бид их судалдаг юм байна. Тэр бол сайн. Угаасаа төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулах талаасаа. Яг төрийн албан хаагчдын өөрсдийнх нь ер нь сэтгэл ханамж хандлага ямар байгааг сүүлийн жилүүдэд бид судалдаг боллоо шүү дээ. Төрийн албаны зөвлөл өөрөө их судалж байна, сайн байна. Энэ дээр суурилж байж бид нар чинь төрийн албаныхаа чадавхыг бэхжүүлэх бусад төрийн албан хаагчдын нийгмийн болон цалин хөлс бусад баталгааг хангахтай холбоотой бодлого тодорхойлдог л доо. Тэгэхээр энэ жилийн та бүхний судалгаа үнэлгээнээс юуг голлох ямар чиглэлийг бид барих ёстой вэ? Бид цаашдаа бол энэ Байнгын хорооноос ямар нэгэн тогтоол гаргах бол юун дээр анхаарах ёстой гэсэн ийм асуулт байна аа.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн бол хийгдэх нь зүй ёсны асуудал л даа. Оролт гаралт байх ёстой. Төрийн байгууллагын тоо буюу эрүүл мэнд, боловсролын салбарын байгууллагуудын тоо нэмэгдсэн хэдий ч төрийн албан хаагчийн тоо 5.9 хувь буюу 13 мянгаар буурсан. Энэ бууралтын нөхцөл байдлуудыг бол бид нар нэлээн дүн шинжилгээ хийж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Сангийн яамтай хэд хэдэн удаагийн уулзалтууд хийсэн. Бид нарын барьж байгаа бодлого болон өгч байгаа саналууд юу вэ гэхээр чиг үүргийн шинжилгээг л зөв хий. Чиг үүргийн шинжилгээг зөв хийж байж зөв ажлын байрны нэршил гарч ачааллын тэнцвэржүүлэлтийн байдлыг та нар ханга гээд. Нийт 2025 оны жилийн эцсийн байдлаар 213 мянган төрийн албан хаагч бол хүн амын 6 хувь, ажиллах хүчний 14.5 гэдэг бол OECD-ийн улсуудтай харьцуулаад үзэхэд энэ тийм өндөр түвшний тоо биш. Хэдийгээр бид нар OECD-ийн юунд ороогүй ч гэсэн ер нь дундаж тэд нарын тоо нь бол нэг 15 хувь гэж байдаг юм байна лээ. Бид нар энийг сүүлийн 2 жил судалж байна л даа.

Тэгэхээр төрийн албан хаагчдын тоог бууруулна гэдэг маань яг үнэндээ тодорхой судалгаа шинжилгээнд хийгдээгүй батлагдчихсан ажил шүү дээ. Бид нар энийг тухайн үедээ маш олон удаа ярьсан. Энэ чинь зөв юм уу буруу юм уу? Яг яагаад бууруулалт хийхээр болчхов гэдэг асуудлыг маш олон байгууллагуудаас асуусан хэдий ч хариултаа авч хараагүй.

Системийн дахин инженерчлэлтэй холбоотой асуудал дээр зүгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газартай л уулзалт хийж ганц 2 удаагийн ажил зохион байгуулсан. Энэ рүү бид нар яг орохгүй байгаа. Бид нар гол нь юу хийж байна гэхээр хуульд заасан үүргийнхээ дагуу чиг үүргийн шинжилгээг л зөв хийх тал дээр нь байгууллагуудтай нэлээн ажиллаж байгаа.

Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг 2024 онд манайх хийлээ, 2025 онд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хийсэн. Ерөнхийдөө бол нийтлэг гарч байгаа асуудал нь юу юм бэ? Ноднингийн 330 сум, 7 бүсийн зөвлөгөө хийхэд хамгийн эхэлж гарсан асуудал нь сургалт хөгжлийн асуудал байсан. Бид нар сурмаар байна, хөгжмөөр байна гэдэг.

Хоёрт нь ажлын байрны орчны асуудал байсан.

Гуравт нь харилцан адилгүй цалин хөлсийг болон нийгмийн баталгааг цэгцэлж өгөөч гэсэн. Ийм эрэмбээрээ төрийн албан хаагч нар санал хүсэлтээ гаргаж байсан. Үүнийг Засгийн газарт танилцуулаад тодорхой шийдвэр гаргасан хэдий ч өнөөдөр болтол хэрэгжилт нь тийм хангалттай сайн биш байгаа. Зулпхар гишүүн тодруулъя.

**С.Зулпхар:** Цэдэвсүрэн даргад баярлалаа. Энэ сургалттай холбоотой зүйл дээр 2019 оноос хойш ер нь сургалтын хөтөлбөр шинэчлэгдээгүй гэдэг дүгнэлтийг та бүхэн хийчихлээ. Миний авсан мэдээллээр жил болгон сургалтын хөтөлбөр шинэчлэгдэж байгаа. Судалгаагаа өөрсдөө хийгээд тэрүүгээр агуулгаа сургалтын зохион байгуулалтаа ч гэсэн янзлаад явж байгаа. Та бүхэн бас судалгаа хийгээд ер нь цаашдаа сургалтаа яах вэ гэдэг дээр их чухал дүгнэлт гаргаж байгаа юм байна. Сайн байна.

Нөгөөтээгүүр ийм дүгнэлтийг та хэд хийсэн үү? Энэ 2026 оны төсөв батлахдаа бид нэг ч сургалтын нэг ч төгрөг тавиагүй шүү дээ. Удирдлагын академи дээр. Танай дээр бол харин сургалтын судалгааны зардал тавьчихсан байгаа шүү

дээ. Энэ дээр ямар нэгэн байдлаар та бүхэн зөвлөмж өгч байна уу? Сургалт зохион байгуулах ёстой байгууллага чинь сургалтын ямар ч төсөвгүй тэгээд төрийн албан хаагчид нь өөрийнхөө мөнгөөр сураад явж байгаа. Ийм ний нуугүй хэлэхэд хууль зөрчсөн нөхцөл байдал үүсчихсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн ямар байр суурьтай байна вэ гэсэн ийм асуулт байна.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Тодруулъя. Удирдлагын академийн хийж байгаа тэр хөтөлбөр гэдэг нь гишүүнээ 2019 онд ЗГХЭГ болон Төрийн албаны зөвлөл 2 хамтраад баталчихсан төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын агуулга хөтөлбөр одоо болтол шинэчлэгдээгүй байгаа. Ерөнхий агуулга нь гэсэн үг. Энийг бид нар академитай хамтарч шинэчлэх ажлыг ноднинггоос хийж эхлээд ер нь араг ясаа босгочихсон. Одоо 26 ондоо хийнэ ээ. Удирдлагын академиар яг хуульд заасных нь чиг үүргийн дагуу бид нар захиалгат судалгаануудыг шууд хэрэгжүүлж байгаа. Энэ дээр нэг хүндрэлтэй юм гарч ирж байгаа. Яагаад гэхээр удирдлагын академийг заавал нээлттэй тендерт оруул тэгж байж тэр байгууллага шалгарсны дараа санхүүгийн асуудал шийднэ гээд. Гэтэл Төрийн албаны хууль болон бусад эрх зүйн бичиг баримтаараа тэр байгууллага өөрөө энэ төрийн албатай холбоотой судалгааны ажлыг хийх үүрэгтэй. Нээлттэй тендер зарлачихаар нөгөөдөх байгууллага нь тендерт орж ирж чадахгүй. Тийм учраас бид нар Сангийн яам болон.

**Б.Баярбаатар:** Зулпхар гишүүн. Сүүлийн тодруулга.

**С.Зулпхар:** Баярлалаа. Цэдэвсүрэн дарга аа.

Тэгэхээр яах вэ миний дараагийн асуулт байна л даа. Маш тодорхой нөхцөл байдал үүсчихлээ шүү дээ. Би Төрийн албаны тухай хуулиа хэрэгжүүлэхгүй байгаа гэсэн үг. Төрийн албан хаагчдыг сургаж хөгжих зардлыг төр өөрөө тавьж өгөөгүй. Тэгэхээр та бүхэн нэг жилийнхээ тайланг сургалт хөгжилтэй холбоотой бас тодорхой санал дүгнэлт гаргаж байна. Төсвийг нь тавьж өг гэж ийм дүгнэлт та бүхэн хийж байгаа юу? Санал жишээ нь биш энэ чинь дүгнэлт шүү дээ. Санал хэлэх ер л шаардлагагүй хуулийг л хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр энэ дээр та бүхэн ямар байр суурьтай байна.

Нөгөөтээгүүр энэ 2019 оноос хойш ерөөсөө өөрчлөгдөөгүй гэдгийг би гайхаад байна л даа. Тэр үед нь л бид ч агуулгыг нь жил болгон шинэчлээд л явж байсан. Сургалтын хэлбэрүүдийг нь шинэчлээд л явдаг. Ерөнхий агуулга баталсан ч гэсэн хөтөлбөрийн дагуу бүгдийг нь янзлаад л явдаг юм л даа. Тэрийг та бүхэн анализ хийсэн үү юу болсон бэ? Нөхдүүд өөрсдөө та бүхэнд ямар мэдээлэл өгсөн юм бэ? Ингэх юм бол би чинь бүтэн 7 жил юу ч хийгээгүй явж байгаа юм шиг сургалт огт өөрчлөгдөөгүй юм шиг болчихлоо л доо.

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон тодруулга хариулт.

**Л.Цэдэвсүрэн:** Тэр 2019 оны ерөнхий багц сургалтын агуулга нь шинэчлэгдээгүй байсан. Жил болгон шинэчилдэг нөгөө зорилтот хөтөлбөрүүд бол шинэчлэгдээд уян хатан зохицуулалт хийгээд явж байгаа. Сургалт болон судалгааны ажил дээр Удирдлагын академи бол 2025 он болон энэ онд бид нар өөрсдийнхөө батлагдсан төсвөөс захиалга судалгаа болон захиалга сургалтууд дээр мөнгө гаргаж өгч байгаа. Бүр хамгийн сүүлд нэг авсан арга хэмжээ юу вэ гэхээр

Канадын тэр Мерит 2 гэдэг төслийн хүрээнд энэ байгууллагын сургалт судалгааны ажлыг бол маш олон талаас нь дэмжиж санхүүжилт олгож байна.

Тэгэхээр нэгэнт Удирдлагын академи гэдэг энэ байгууллага хуулиар хүлээсэн үүргээрээ Монгол Улсын төрийн албан хаагчдыг сургах, төрийн албаны энэ судалгаа шинжилгээний ажлыг хийх л ёстой юм бол энэ байгууллагын төсөв санхүү дээр нь ингэж хяналт тайралт хийгээд байж болохгүй. Цаашаагаа энэ тэгвэл яг энэ зарчмаараа явбал бид нар төрийн албан хаагчдаас сургах асуудалд маш эрсдэлтэй байдалд орох юм байна лээ. Ер нь Монголын төр өөрийнхөө төрийн албан хаагчийг сургах л ёстой.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

**Б.Хэрлэн:** Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ тайлан үйл ажиллагааны тайлан болоод төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн тайлантай холбогдуулаад хэд хэдэн асуулт байна аа.

Нэгдүгээрт нь төрийн албан хаагчийн тоог 9 хувиар бууруулах тэгээд ингээд улмаар нөгөө төсвийн хэмнэлтийг хийх ийм том зорилтын хүрээнд нэлээн олон хүмүүс ажлаасаа өөрчлөгдсөн байгаад байгаа. Тайланд бичсэнээр 5.9 хувиар төрийн албан хаагчийн тоо буурсан гэж байна. Тэгэхээр энэ дээрээс би юу асуух гээд байна вэ гэхээр ер нь энэ хүний нөөцийн зардал хэмнэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлс нийгмийн баталгаа сургалтын зардлууд хэмнэгдсэнтэйгээр холбоотойгоор хэдэн төгрөг яг өнөөдөр хэмнэгдэж чадсан юм бэ? Тэрийг ер нь та нар харж үзсэн үү? 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ бодлогыг хэрэгжүүлэхэд бүтэц зохион байгуулалтын хувьд, төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийн хувьд энэ бодлого ер нь сайвар нөлөөтэй байв уу, саар нөлөөтэй байв уу гэдэг дээр Төрийн албаны зөвлөл энэ дээр дүн шинжилгээ хийсэн үү?

Хоёрдугаарт нь энэ тайланг харахад 2024 оны тайланд та нар төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгааны талаар тодорхой яг нэг бүлэг болгож ирээд бичиж байсан байна л даа. Тэгэхээр 2025 онд сая нэлээн олон албан хаагч ажлаасаа өөрчлөгдчихлөө. Тэр хүмүүсийн нийгмийн баталгааны асуудал, цалин хөлсний асуудал гээд энэ асуудлууд нэлээн л гарч ирсэн баймаар. Гэтэл 2025 оны тайланд яагаад энэ төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, цалин хөлсний тухай асуудал тусаагүй юм бэ гэдгийг хоёрдугаарт нь асууя.

Гуравдугаарт нь төрийн албан хаагчид ер нь төрийн албанд энэ орох гарах энэ маш их байна. Ер нь тогтвор суурьшил ер нь жаахан бага байна гэж. Ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын 13 хувь нь ингээд 2024 онтой харьцуулах юм бол ажлаасаа орж гараад байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдын 15.3 хувь нь 2024 онтой харьцуулах юм бол орж гараад байна. Энэ чинь одоо уг нь төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог бууруулах цөөрүүлэх тухай бодлого авч хэрэгжүүлээгүй гээд байгаа. Тэд нарын цалин мөнгийг нэмээд байхад яагаад ийм байдал үүсээд байгаа юм, 1 дүгээрт.

Тэгээд дээр нь нолиос 10 жил ажилласан албан хаагчдын ер нь ажлаасаа тогтвор суурьшилтай ажиллахгүй гараад байна гээд. Энэний учир шалтгааныг, энийг засаж шийдвэрлэх талаар Төрийн албаны зөвлөлөөс яг ямар бодлого, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх гээд байгаа юм? Энийг асууя гэж бодож байна.

Дөрөвдүгээрт нь нийтийн албанд томилогдох эрх хасуулсан 1537 иргэн сүүлийн 6 жилд бүртгэгдсэн. Энэний 29.1 нь эмэгтэй, 70.9 хувь нь эрэгтэй хүн байна гээд. Ингээд эрхээ хасуулахаараа ер нь бол дийлэнх нь 60 гаруй хувь нь болоод ирэхээр ердөөсөө 2 жилийн хугацаатайгаар л төрийн албанд ажиллахгүй байхаараа ийм хариуцлага тооцуулаад явчихдаг юм байна гээд энэ дээр тайлан дээр бичсэн байгаад байна л даа.

Тэгэхээр энэ дээрээс би яг юу асуух гээд.

**Б.Баярбаатар:** Хариултаа авчхаад дараа нь тодруулах уу? Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчдын тооны бууралттай холбоотой яг санхүү төсвийн үр ашиг гарсан талаарх мэдээлэл байхгүй аваагүй. Сангийн яаманд хүсэлт тавьчихсан байгаа. Ер нь яг 2025 оны төсвийн гүйцэтгэлээр яг ямар үр дүн гарсан юм бэ? Асуудал нь яг байсан юм уу, хэдэн хүнд тэтгэмж өгсөн юм? Энэний үр дүнгийн санхүүгийн тайланг ирүүлээч гэсэн. Тэрийгээ бид нар авч байж энэ харьцуулсан дүн шинжилгээгээ нэлээн сайн хийх байх аа.

Төрийн албан хаагчдын тоог 13 мянгаар буугаад тэрэн дундаа ялангуяа 35 хүртэлх насны 0-10 жил ажиллаж байгаа залуу үе тэрэн дотроо бүүр эмэгтэйчүүд давамгайлсан гүйцэтгэх албан тушаалууд ингээд төрийн албанаас гараад байгаа нь түрүүн хэлдгээр бид нарын ерөөсөө хүлээсэн үр дүн биш байлаа. Төрийн албаны үйл ажиллагаанд энэ ямар нөлөөлөл үзүүлж байгаа юм бэ гээд. 2025 онд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас хийсэн иргэдээс авсан санал асуулга дээр бол төрийн үйлчилгээний хүртээмж чанар дээр тодорхой хэмжээний юу гэдэг юм бууралт сэтгэл ханамжгүй байдал гэдгээсээ илүүтэй төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний бодит бус байдлыг эргэж хараач гэдэг асуудал нэлээн яригдсан. Өнөөдрийн Засгийн газар ч гэсэн яг энэ дээр ажиллаж байгаа. Бид нар хамтраад нэг ажлын хэсэг байгуулчихсан ажиллаж байна. Юу вэ гэхээр энэ төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөлт үнэлгээний журмыг шинэчлэх, ялангуяа бодит зөв үнэлгээ хийх асуудал дээр нь энэ журмаа 2 талаасаа нэлээн сайн ярилцаж хийе.

Нөгөө талаасаа төрийн албан хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхтэй холбоотой бодлогын том шийдлүүдийг гаргая гэсэн ийм зүйлийг хийж байна аа. Өнөөдрийн байдлаар энэ хэдэн хүн 13 мянган бууралт маань тэтгэмж хэдийг нь авсан юм, хэд нь ямар цалин хөлстэй ажилласан юм бэ гэдэг дээр яг үнэндээ танд өнөөдөр би тоо хэлж чадахгүй нь ээ. Бид нар Сангийн яамнаас авсан тоо баримтаа шаардлагатай гэвэл танд дүгнэлт хийгээд хүргүүлье гэж бодож байна аа.

Ямар бодлого барьж байгаа юм бэ гээд бид нар нэг талдаа 0-10 жил ажиллаж байгаа энэ залуу хүмүүс төрийн албанаас гараад байна. Гэтэл нөгөө талдаа манай байгууллага яаж байна гэхээр төрийн албанд орох нөөцөө бэлдээд байгаа. Түрүүн хэлсэн 18 мянга гаруй хүнээс бид нар 5 мянган хүнийг л төрийн албанд оруулж байна. ТЗ рүү. Тэгвэл бусад нь яагаад орж болохгүй байгаа юм бэ. энэ дээр манайх ямар ажил хийдэг юм бэ гэхээр төрийн захиргааны байгууллагуудын ажлын байрны нэр болон түүний чиг үүрэг ажлын ачаалалтай холбоотой асуудлыг албан тушаалын тодорхойлолтоор нь цэгцэлж янзалж эхэлсэн. Та нар ингэж хүнд зориулсан юм шиг

нэг талдаа нөгөө төрийн албанд оръё гээд байгаа залуу үеийг ажилд авахгүй юм шиг шууд ахлах мэргэжилтэн, шинжээч, ахлах шинжээч гэдэг ажлын байруудыг ихээр бий болгохыг хориглоно гэж зөвлөөд мэргэжилтнээс нь эхлээд ажлын байруудыг бий болгож эхэлж байгаа. Ингэх юм бол нөгөө бид нарын нөөц гээд бүртгээд байгаа олон залуу үеийнхэн ажилд орох магадлал нь ихэснэ. Энийг бол ямар ч байсан 2025 онд нэлээн хийж эхэлж байсан. Тэгээд саяын 9 хувийн бууралт бид нарт нөлөөлчихлөө л дөө.

Нөгөө талаас тэр нийтийн албанд ажиллах эрхээ хасуулсан хүмүүс 2-8 жилийн шүүхийн шийдвэр гардаг юм. Энэ эрхээ хасуулсан нийт хүмүүсийн дийлэнх нь нөгөө хуульд заасан авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон. Тэгээд энэ хүмүүс буцаж төрийн албанд орохгүй. Ер нь 90 гаруй хувь нь яг энэ чиглэлийн хүмүүс байгаа. Тэгэхээр 2-8 жилийн хугацаанд энэ эрхээ хасуулаад шүүхийн шийдвэр гүйцэтгэхийнхэн манайх руу шууд системээр мэдээлэл ирэнгүүт бид нар энэ бүртгэлээ хийгээд тэгээд буцаагаад энэ хүмүүс хаа нэгэн газар өөр ажилд орчих вий дээ гэдэг юмаа бид нар системээр хянаад явж байгаа.

Тэгэхээр энэ бол 2026 онд бас нэг сонин юм юу гарсан гэсэн чинь Монгол Улсын шүүхээс энэ Хятад иргэдэд ийм у ял оногдуулдаг юм байна. Тэгээд тэр нь зарим тохиолдолд нөгөө төрийн үйлчилгээний доод түвшний албан тушаалд орох эрсдэл байдаг учраас тэр талын мэдээллээ манайд ирүүлдэг болсон. Энэ дээр бид нар гар бүртгэл хөтлөөд.

**Б.Баярбаатар:** Хэрлэн гишүүн тодруулна.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр 1 дүгээр асуулт дээр би зөвхөн нөгөө төсвийн хэмнэлтээс гадна байгууллагын үйл ажиллагаанд төрийн үйлчилгээний чанар хүртээмж энэнд яаж нөлөөлж байгаа юм бэ гэдэг дээр нөгөө 9 хувиар бууруулна гээд одоо 5.9 хувиар бууруулчихсан байна шүү дээ. Энэ эргээд ер нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид яаж нөлөөлөөд байгааг танайх судалж үзэв үү гэж.

Хоёрдугаарт нь би тэр асуултаа тодруулчихъя л даа. Ер нь энэ хувь хүнээс өөрөөс нь хамаарахгүй хүч хүчин зүйлээс энэ хууль эрх зүйн зохицуулалтаас болоод ч юм уу нөгөө төрийн албанд ажиллах эрхээ хасуулахад ингээд хүрээд байдаг юм биш биз дээ? Энэ дээр та нар дүн шинжилгээ хийж үзсэн үү? Саяхан 1 кэйс яригдсан л даа. Нэг сургуулийн захирал өвөл халаалтаа нөгөө тендер зарлахгүйгээр халаалтын зуух нь доголдонгуут нутгийнхаа нэг чадвартай хүнээр хийлгэгчихсэн чинь дараа жил нь хариуцлага татагдаад явчихсан гээд л. Тэгэхээр энэ мэтчилний асуудлууд дээр та нар авч үзсэн үү гэж ер нь анхаарал хандуулж үзсэн үү?

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга тодруулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Төрийн албан хаагчдын тооны бууралт нь төрийн албаны үйл ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааны чанар бүтээмжид хэрхэн нөлөөлж байгаа судалгааг яг албан ёсоор 2025 онд хийгээгүй. Тэрийг энэ онд хийхээр захиалгаа Удирдлагын академид өгөх үү эсвэл нээлттэй тендер зарлах уу гэдгийг арай шийдээгүй байна. Аль нэгэн хувилбараар энийг хийнэ. Хийх гэж байгаа.

Хоёр дахь асуултын хувьд бид нар ШШГЕГ-тай системийн интеграц хийгээд энэ мэдээллүүдийг авдаг. Авахдаа шүүхийн тэр шийдвэр болон процессын үйл

ажиллагаанд оролцдоггүй. Ерөөсөө л яг хуульд заасны дагуу төрийн албанд болон нийтийн албанд ажиллах томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн бүртгэлээ хөтлөөд тэр хүмүүс буцаад төрийн албанд аль нэгэн ангилалд ажилд орох вий гэдэг эрсдэлийг л хянадаг ийм манай систем байгаа. Тэрнээс биш шүүхийн дотоод үйл ажиллагаа болон шүүхийн шийдвэртэй холбоотой ямарваа нэгэн байдал руу ордоггүй.

**Б.Баярбаатар:** Хэрлэн гишүүн сүүлийн тодруулга.

**Б.Хэрлэн:** Миний 2 дахь асуулт орхигдчихлоо. Тэгэхээр 2024 оны тайланд танай үйл ажиллагааны тайланд төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудал тодорхой тусаж орж ирсэн. 2025 оны тайланд яагаад тусаагүй юм бэ? Ялангуяа 2025 онд чинь төрийн албан хаагчдыг бууруулах ийм бодлого хэрэгжүүлээд бүх түвшиндээ хүмүүсийг ажлаас нь чөлөөлөх ийм явагдчихлаа шүү дээ. Тэгэхээр яагаад энэ тайланд, 2025 оны тайланд яагаад төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгааны асуудал өмнөх он шигээ тодорхой тусаж орж ирээгүй юм бэ?

**Б.Баярбаатар:** Индрийн микрофон Цэдэвсүрэн дарга тодруулъя.

**Ц.Цэдэвсүрэн:** Товч танилцуулахдаа хэлсэн. Бид нар 2023 онд, 2024 онд тайлангаа явуулахдаа тодорхой маш их саналуудыг хүргүүлдэг ч хэдий энэ маань нэг их тийм хэрэгжилт сайн биш байгаа учраас үүн дээрээ нэмье гэдэг зарчмаар нэмэлт 17.

Тэгэхээр бид нарын 2023, 2024 оны тайланд өгсөн саналууд дахиад энд орчихсон байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхдээ бид нар ингээд зүгээр тайландаа санал хавсаргаад зогсчихдоггүй. Энийг тодорхой хувиар их бага хэмжээгээр биелүүлэх нь төлөө Засгийн газар, Их Хурал болон холбогдох төрийн байгууллагуудтай бол нэлээн сайн хамтарч ажиллаж байгаа. Энэ хүрээндээ 38 хуулиар энэ төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгааны асуудлыг зохицуулаад байгааг ер нь 2026 онд энэ Төрийн албаны хуулийн шинэчлэлийн реформыг ер нь зоригтой хийвэл хийгээд явъя гэдгийг Засгийн газартай хэд хэдэн удаагийн уулзалтаараа яриад байгаа. Тэгээд сая хамгийн сүүлд Улсын Их Хурлын дарга бол та нар хуулийн төслөө өөрсдөө хийж авчир гэдэг үүргийг өгчихсөн. Бид нар энэ дээр.

**Б.Баярбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Би ганц, хоёр асуулт асууна.

Төрийн албаны зөвлөл бол чадахын хэрээрээ л ажиллаж байгаа зөвлөлийн гишүүд. Зүгээр яах вэ хууль тогтоомжийнхоо хязгаар өгөгдсөн боломж бололцоогоор энэ Төрийн албаны зөвлөл чиг үүргийнхээ дагуу яг энэ чадамжтай ажиллаж чадаж байгаа юу гэдэг 1 дүгээр асуулт. Энэ төрийн албаны улс төржилт гэж нэг том асуудал байгаа. Дотроо 2 ангилна. Томилгоо улс төржилтгүй явагдаж чадаж байгаа юу. Үйл ажиллагаа улс төржилтгүй явагдаж чадаж байгаа юу гэдэг асуудал. Түрүүн та мерит зарчим зарим тохиолдолд мөрдөгдөхгүй байгаа гэж хэллээ. Дунд, доод шатандаа мерит зарчим мөрдөгдөж байгаа. Удирдах албан дээр очоод ирэхээр мөрдөгдөхөө байчхаж байгаа юм. Энийг чинь дагаад тэр залуучуудын итгэл үнэмшил буурч байгаа юм аа. Би төрийн албанд ажиллаж байгаа

олон ах дүү найз нөхдүүд байна. Өчнөөн жил ажиллаад л мерит зарчмаа хараад л явж байтал гэнэтхэн гаднаас нэг хүн газрын дарга нь болоод ороод ирдэг.

Тэгэхээр тэр чинь доод албан тушаалтнууд нь эрх биш хүн л юм байна тэгээд дургүйцлээ илэрхийлнэ шүү дээ. Ажлаа мэдэхгүй нөхөр дээр нь гарч ирээд чиг үүрэг өгөөд суучихаар. Тэгээд итгэл үнэмшил суларч байгаа учраас энэ залуучууд чинь төрийн албанаас гарч байгаа. Энийг дагасан дарамт хууль бус нөлөөлөл эргээд бид нар төрийн албан хаагчдаа хамгаалж чаддаггүй шүү дээ. Баахан ажлаар шахаж шахаж ажиллуулж ажиллуулчхаад. Буцаагаад яг асуудал ярихаар болохоор төрийн албан хаагчдаа бид нар хууль эрх зүйн талаар нь ч тэр хүн харилцааны талаасаа ч бид нар хамгаалж чаддаггүй.

Нөгөө муу л бол хойд хар овоохой гэдэг шиг. Нөгөө хэдэн төрийн албан хаагчид руугаа л дайраад байдаг. Их сүрийг үзүүлнэ шүү дээ төрийн албан хаагчдадаа ер нь.

Тэр 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тэр 9 хувь буруу. 9 хувийн цомхотголыг би тухайн үед протоколд үлдээж байсан юм. Эсэргүүцэж үг хэлээд.

Нэгдүгээрт би ямар үндэслэлээр. Эдийн засаг хөгжлийн яам яахаараа төрийн албаны цомхотголыг оруулж ирдэг юм гэж. Төрийн албаны зөвлөлөөс санал аваагүй. Тэгээд энэ юу үзүүлж байна гэхээр түрүүний Ариунзаяа гишүүний хэлдэг тэр Төрийн албаны зөвлөл шүдгүй гэдэг чинь энэ байхгүй юу. Зарим тохиолдолд Төрийн албаны зөвлөл гүйцэтгэх засаглалаа гуйгаад явж байдаг. Их Хурлын дэргэдэх байгууллага. Одоо би энэ хар аа, надад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын бичиг энэ байна. Энэ Гадаад хэргийн яамных энэ байж байна. Энэ 9 хувьтай холбоотой. 3202 орон тооноос 9 хувь буюу 285 орон тоог цомхотгож Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжилтийг хангасан болно оо.

Үүн дотроос удирдах албан тушаалд 6, 262 нь энгийн байгаль хамгаалагчийг ажлаас нь чөлөөлчихсэн байгаа байхгүй юу. Энэ тал дээр Төрийн албаны зөвлөл ямар үнэлэлт дүгнэлт өгөх вэ? Энэ судалгааг ер нь хийсэн үү? Та нар. Энэ 262 хүний ард хэдэн ам бүл байгаа бол. Хэдэн оюутан хүүхдүүд байгаа бол? Тэгэхээр энэ асуудлууд дээрээ бид нар энэ ултай суурьтай хандах ёстой. Ер нь энэ 2017 онд батлагдсан хууль үнэлгээ хийгдсэн гэж би ойлгож байгаа. Хэрэгжилтийн үнэлгээ. Одоо манай Зулпхар гишүүн та Удирдлагын академийн захирал байсан. Төрийн албаны чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажлуудыг олноор хийсэн. Та энэ дээр манлайлал үзүүлэх ёстой. Энэ хуулийн ажлын хэсгийг та ахлаад энэ үнэлгээтэй танилцаад буцаж танилцаад, бидэнд танилцуулаад. Би энэ дараагийн энэ Төрийн албаны хуулийн шинэчлэл дээр юу харж байгаа гэвэл Төрийн албаны зөвлөл тест боловсруулж шалгалт авдаг байгууллага биш шүү. Их Хурлын нэрийн өмнөөс гүйцэтгэх засаглалын томилгоо, сонгон шалгаруулалт, энэ бүгдэд нь хяналт тавьж хууль зөрчсөн тохиолдолд энэ асуудлыг нь таслан зогсоодог эрх бүхий байгууллага бол Төрийн албаны зөвлөл байх ёстой.

Одоо жишээлбэл тэр мерит зарчим түрүүн зөрчигдлөө гээд та хэллээ шүү дээ. Тэрийг зөрчсөн албан хаагч ямар хариуцлага хүлээв. Хуульд чинь Төрийн албаны хуульд чинь мерит зарчим гээд заагаад өгчихсэн байгаа шүү дээ. Тэгтэл зөрчөөд томилгоо хийчихсэн байна шүү дээ. Энэ дээр танайх хариуцлага тооцох үндэслэл чинь хууль эрх зүйн орчноор чинь та нарт байхгүй байхгүй юу. Тэгээд энийг товчхондоо бид нар шүдгүй арслан гэж хэлээд байгаа юм аа. Тэгэхээр би энэ

саяын энэ асуудлууд дээр нэг тодорхой хариултуудыг товч хариултуудыг авчихъя гэж бодож байна.

Тэгээд дараа нь гишүүд үг хэлэх горим байгаа.

**Л.Цэдэвсүрэн:** Баярбаатар даргын асуултад хариулъя.

Эхнийх нь төрийн албан дахь улс төрийн үйл ажиллагаа гээд өмнө нь тайлан болон холбогдох ажлын хэсгийн хурал дээр ч хэлж байсан. Улс төрийн нөлөөлөл бол төрийн албанд хууль баталж өгөх, тодорхой төсөв баталж өгөх гээд ингээд энэ ажил байлгүй л яах вэ. Бид нарын хамгийн гол нь улс төрийн нөлөөллийг битгий энэ төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх харилцаа руу оруулаад байгаач л гэдгийг үе үеийн сайд нар Засгийн газрын тэргүүнүүд болон холбогдох байгууллагууд руу Засгийн газар солигдох тохиолдол болгонд энийг бүр албан ёсоор ингэж зөвлөмж санал явуулж байгаа. Гэсэн хэдий ч энэ бол нөлөөлөл нь байсаар байгаа, байсаар л байна, байсаар байгаа.

Өнөөдөр энэ Монгол Улсын төрийн албанд энэ бүтцийн өөрчлөлт гэдэг юмыг яг зөв ойлгож хийдэг асуудал аягүй хэцүү болчихоод байна. Бид нар энийг зөв талаас нь маш олон удаагийн зөвлөмж өгөөд бүтцийн өөрчлөлт чинь ийм шүү хууль нь ийм шүү гээд хэлээд байгаа, бичээд байгаа саналаа өгөөд байгаа хэдий ч зүгээр л нэг байгууллагынхаа үйл ажиллагааны орон тоог жоохон өөр болгоод л 1 нэгжийн нэрийг өөр болгосныг бүтцийн өөрчлөлт гээд л орж ирээд байгаа. Энийг бид нар юугаар хааж чадаж байгаа юм бэ гэхээр албан тушаалын тодорхойлолтыг хянаж зөвшөөрөл олгох иж бүрэн цахимжуулах ажлаараа цэгцэлж чадаж байна эхнээс нь. Тэгэхдээ энэ бид нарын хүссэнээр бүрэн хэмжээнд дуусаж чадахгүй л байна л даа. Энэн дээр манайх юу өгдөг юм бэ гэхээр зөвлөмж л өгнө, санал өгнө, дүгнэлт гаргаж өгнө, энэ чинь болохгүй байна гээд. Аудитаар яг тэгсэн. 16 яамны аудитаар меритийн зарчим алдагдчихсан байна гэдэг дээр бүх яамд болон ЗГХЭГ-т зөвлөмж хүргүүлсэн хугацаатай. Аудитын зөвлөмжийг заавал биелүүлэх ёстой. Энэ хугацаанд хэрвээ тэр зөрчил арилаагүй, биелүүлээгүй бол манайх шууд албан ёсоор хяналт шалгалтын ажлаа оруулаад гаргасан шийдвэрүүдийг нь хүчингүй болгоно. Тэгэхээр хугацааны дотор тодорхой хэмжээний асуудлууд цэгцрэх болов уу гэж найдаж байгаа. Нөгөө талаасаа 9 хувийн бууралт дээр таны хэлдэг зөв. Манайхаас санал аваагүй.

Хэрвээ авсан бол бид нар энэ дээр шал өөр санал өгөх байлаа. Яаж 9 хувь? Яагаад заавал 9 хувь. Хэнийг нь? Ямар учраас? Гээд ингээд зөндөө олон асуултууд цаана нь үүснэ. Энэ дээр бид нараас санал аваагүй хэдий ч манай нэгдсэн тоо бүртгэл дээр яах аргагүй л 5.9 хувьтай гарчихлаа. Тэгээд энэ ажлаасаа гарч байгаа энэ шилжилт хөдөлгөөн их хийгдэж байгаа дээр яах вэ бид нар бодохдоо бүтцийн өөрчлөлтийнх нь тоо маш давамгай гарч ирэх байх гэсэн чинь 716 байх юм. 4 мянга гаруйхан хүн нь болохоор нөгөө нэг түр чөлөөлөгдөөд гараад явчхаж байгаа энэ хугацаанд нь декретээ авдаг ч юм уу хүүхэд харъя, эсвэл би суръя, эсвэл би өвдөөд байна гээд. 18 мянга гаруй хүмүүс нь зүгээр өөрсдөө санаачилгаараа энэ төрөөс гаръя гээд гараад явчхаж байгаа нь бид нарын түрүүний хэлдэг ерөөсөө төсөөлж байгаагүй тоо ороод ирчихсэн.

Энэ дээр бүх талаас нь санхүү болон үйл ажиллагаа талаас нь нэлээн нарийн дүн шинжилгээ хийгээд явж байна. Энийгээ Засгийн газарт албан ёсны ийм нөхцөл байдал үүсчихлээ. Та нарын 9 хувийн бууралтын үйл ажиллагаа яг бодит байдал

дээрээ зөв явахгүй байгаа юм байна гэдэг тийм санал дүгнэлтүүдийг өгсөн. Тэгэхээр яах вэ энэ дээр манай бодлого бид нар болохоор аль болохоор яг төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах талдаа илүү бодлого маань явдаг. Хяналт шалгалт маань номер нэгд байдаг ч гэлээ нөгөө талдаа бид нар шууд өөрсдөө яг энэ хүний нөөцийн асуудал дээр шийдвэр гаргах эрхгүй учраас зөвлөмж зөвлөгөө, дүгнэлт, санал гэсэн юмнууд тасралтгүй өгөөд байгаа хэдий ч тодорхой бас нэг тийм үр дүн наашаа гарахгүй байх магадлалтай л байна.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Одоо гишүүд үг хэлнэ. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. 3 гишүүн байна. Хэрлэн гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** 18 мянган хүн өөрийн хүсэлтээр ажлаасаа гарсан гээд ер нь яах вэ тодорхой гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ анализ хийх юм бол дарамталж байгаад өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гарга гэж дарамт үзүүлсэн тохиолдлууд ч гэсэн байдаг л даа. Тэгэхээр энэ агуулгаараа дотор нь бол яагаад өөрийнхөө хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргаваа, чөлөөлөгдөв өө гэдгийг ч гэсэн гүнзгийрүүлээд судалдаг бол уг нь сайн. Тэгээд энэ ч учраас ер нь Төрийн албаны зөвлөлийг шүдгүй арслан гэж хэлсэн хүний хувьд шүд нь тэгвэл хэн байх юм бэ гэдэг ийм асуултыг энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд бодох хэрэгтэй байх. Улсын Их Хурлын харьяа байгууллага юм бол Төрийн албаны зөвлөл сард нэг удаа чуулган чинь цөөн хэдэн хоног л цөөн хэдэн сар л жилдээ 2 удаа л чуулж байгаа шүү дээ. Тэгээд энэ хугацаандаа жилдээ ганцхан удаа уулзаж тайлангаа л ярьдаг биш, магадгүй сар тутамдаа нэг удаа яг тулгамдаж байгаа асуудал Байнгын хорооноос ямар чиглэл тогтоол гарган гаргаж болох вэ гэдэг агуулгаар нь уг нь ажиллачих юм бол энэ хүндрэлүүдийг тодорхой хэмжээнд шүдтэй болгох ийм боломж гарах болов уу гэж миний зүгээс үзэж байна аа. Нэн ялангуяа энэ ажлын байрны дарамт болон ажлын байрны бэлгийн дарамтын асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороогоороо та хэд мэдээлэл нь бэлэн байгаа бол ойрын хугацаандаа сонсоод тэгээд түүнийгээ цаашлаад бид нар конвенцод нэгдэх ч асуудал байгаа. Энэ асуудлуудаа шуурхай явуулах хэрэгцээ шаардлага байна уу даа гэж харж байна.

Төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хамгаалж дуугарах шаардлагатай байна гэж түрүүн Гантөмөр дарга ч гэсэн хэллээ. Та нар чанга дуугарах хэрэгтэй байна гэж. Төрийн албаны юу гэдэг юм хуулиар хамгаалагдсан байгаа зүйл заалтыг төсөв дагуулж, төсвийн тодотгол дагуулж, тухайн заалтыг 9.2 байх төрийн албаны хүчингүй болгох ийм заалтыг оруулж ирж байгаа шүү дээ. Түүнийг анзаарч би тухайн үедээ бараг л ганцаархнаа шахуу орилж байгаад л ёстой ийм юм байж болохгүй гэж тухайн төсвийн тодотголыг дагаж орж ирсэн энэ хуулийг буцааж байсан. Төрийн албан хаагчдын энэ тэтгэвэрт гарахад нэг удаа олгодог 36 сарын тэтгэмжийн 50 хувийг нь л оруулж ирээд л баталсан шүү дээ. Тэгээд л тухайн үед нь энэ чинь болохгүй шүү дээ гэж нөгөө ёстой жинхэнэ орилж байгаад гэдэг шиг. Тэгээд Занданшатар дарга уг нь бол эхэлж тэтгэвэртээ гарч байгаа хүмүүсийг бүрэн дүүрэн өгнө өө. Тэгээд дараа дараагийн хүмүүсийг дараа нь гараач гэж хүсэлт гаргана гэж байсан чиг яг бодит амьдрал дээр бол 50 хувийг нь өгөөд л 50 хувийг нь өгөхгүй л явж байгаа. Ам ажил 2 зөрж байгаа байхгүй юу.

Зүгээр Сангийн сайд төсвөө яаж хэмнэх вэ гээд л Сангийн яамны хэн нь ч байдаг юм гэнэт өглөө сэрээд л. Ер нь энэ докторын нэмэгдлийг больё. Ер нь тэр бусад бүх нэмэгдлүүдийн 40 хувьд барья гэсэн ийм л юм оруулж ирж байгаа шүү дээ. Яаж ингэж ийм механик аргаар ингэж болдог байна аа. Төрийн албанд нэг

хүрэхгүй хувь докторууд байгаа шүү дээ. Төрийн улс төрийн албанд 50 хэдхэн доктор гэх мэтчилэн ингээд төрийн албан хаагчдынхаа өмнөөс дуугарч төрийн албан хаагчдаа хамгаалдаг энэ байгууллага хэрэгцээтэй байгаад байна аа. Тэгэхээр энийг бол Төрийн албаны зөвлөл өөрөө хийж чадахгүй юм гэхэд Төрийн байгуулалтын байнгын хороондоо мэдээллүүдийг өгч явмаар байна.

Цалингийн цалин хөлсний нэгдсэн бодлого ер нь Засгийн газар дээр алдагдсан. Хэн хүчтэй сайд нь тэр нь юмаа явуулдаг, хэн гудамжинд жагсаж чадна тэр нь цалингаа нэмүүлдэг. Цалин хөлсний бодлогыг тэгвэл бид нар яах ёстой юм бэ? Төрийн албаны зөвлөл энэ асуудлаа бидэнд танилцуулмаар байна. Ийм саналтай байна.

**Б.Баярбаатар:** Баярлалаа Зулпхар гишүүн саналаа хэлье.

**С.Зулпхар:** Бид ингээд сая хэлсэнчлэн тодорхой хугацаанд Төрийн албаны зөвлөлийнхөө мэдээллийг сонсоод шаардлагатай бол эндээс улс төрийн дэмжлэг үзүүлэх нь бидний үүрэг, Улсын Их Хурлын үүрэг. Улсын Их Хурлаас өөрөө томилогддог эрх үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийн гишүүд байгаа. Цаана бүхэл бүтэн институц байгаа учраас. Нөгөөтээгүүр 2 дахь асуудал ер нь Төрийн албаны зөвлөл бол яах вэ шүдгүй арслан гэдгийг бол 2016 онд их ярьж байгаад бид хуульд нэмэлт оруулаад шинэчилсэн найруулга явсан шүү дээ. Энэний дагуу бол зарим нэг шүдтэй болгочихсон. Тэр шүд нь хэр хурц вэ гэдэг л асуудал байх мохоо байгаа байх. Нэн ялангуяа саяын бидний ярьж байгаа зүйл дээр хяналт шалгалт хийгээд тэгээд хяналт шалгалтаар гаргасан зөвлөмж дүгнэлтийг авч хэрэгжүүлж байгаа байдал дээр бол үнэхээрийн дутмаг байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид сая Цэдэвээ дарга ч гэсэн хэлж байна. Хуулиа өөрчилнө гэж. Хуулиа өөрчлөх бол бид энэ асуудлыг маш тодорхой өөрчлөлт оруулах ёстой. Тэгэхгүй бол ингээд л дараагийн дүгнэлт дараагийн тайланг сонсоход яг ингээд Цэдэвээ дарга ирээд л энийг ярина. Хуульд нь тэр хүнд хязгаартай нөхцөлүүд байгаа учраас энийг их тодорхой оруулж өгөх ёстой гэж бодож байна. Баярбаатар дарга хэлж байна та өөрөө манлайлаад ажлын хэсэг гаргаж байгаа. Миний хуулийн төслийг ахлаад яв гэж байна. Би тэрэнд бол за гэж хэлж байна. Бид энийг хамтдаа манлайлаад явах ёстой. Төрийн албаны зөвлөлтэйгөө, ЗГХЭГ-тайгаа, Хяналт хэрэгжүүлэх газартайгаа, Удирдлагын академитай, төрийн бусад байгууллагуудтай байгууллагуудтай хамтарсан байдлаар хамтарсан байдлаар энийг бол ингээд хийгээд хийх ёстой гэж байгаа юм.

Сайн үр дүнгүүд гарсан. Энэ сонгон шалгаруулалт бол энэ боломжийн түвшинд байгаа шүү дээ. Энэ сонгон шалгаруулалтын систем систем болоод хөгжчихсөн. Энэ анх байснаасаа бол шал өөр шинэ түвшний систем бий болчихсон. Энэ дээр Төрийн албаны зөвлөл өөрөө их сайн манлайлсан. Төрийн алба Төрийн байгуулалтын байнгын хороо үе үеийн Байнгын хороо шүү дээ. Энэ дээр их сайн дэмжсэн юм байгаа юм. Тэгэхээр энийг бид тэмдэглэх ёстой. Олон нийт ингээд л бүх зүйл болохоо байчихсан юм шиг ингээд л бид яриад байвал аягүй болохоо байчихлаа гэж бодно. Гэтэл болж байгаа зүйлийг нь ярих ёстой. Саяын байдлаар шүдийг нь хурцалж өгөх нэг бол байхгүй газар нь шүдийг нь шинээр ургуулж өгөх асуудал байгаа бол тэрийгээ л хэдүүлээ хамтдаа хийнэ гэсэн ийм бодолтой байна.

Засгийн газар өөрөө тэр төрийн албаныхаа менежментийн зарим асуудалд оролцоно уу? Яагаад гэвэл энэ төрийн алба чинь эцсийн дүндээ захиргаа болон

төрийн үйлчилгээ Засгийн газрын өөрийнх нь чиг үүргээр явж байгаа учраас тэрэндээ идэвхтэй оролцдог тэр чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой. Заримдаа ингээд Төрийн албаны зөвлөл рүү асуудлаа шидчихдэг ийм тохиолдол байгаад байгаа байхгүй юу. Яг Засгийн газрын өөрийнх нь хүний нөөцийн менежментийн асуудал байхад. Тэгэхээр энийг бид нар ялгаж салгаж ойлгох ёстой байх гэж бодож байна аа.

Дараагийн зүйл нэг цоо шинэ үе бий боллоо төрийн албанд бол. Ингээд бид шинэ үеийнх нь орж ирж байгаа бол тэд нарт тохирсон байдлаар хөгжлийн асуудал яригдана. Сая Цэдэвсүрэн даргын хэлж байгаа үнэн байхгүй юу. Бид угаасаа буруу юм хийчихсэн байхгүй юу. Тэр сургалтын хөтөлбөрийг аваачаад Засгийн газраар баталж байдаг ямар хэрэг байгаа юм, хэрэггүй байхгүй юу. Тэр үед бид хэрэггүй гэж байсан тэгээд л тийм болгоод хаячихсан байхгүй юу. Энд аливаа сургалтын байгууллага байна шүү дээ, сургалтынхаа хөтөлбөрийг өөрийнхөө эрдмийн юм уу сургалтын зөвлөлөөр л баталдаг байхгүй юу. Ийм сонин гаж юм бид нар хийчихсэн байхгүй юу. Тэгээд хэдэн жил тэр нь бол өөрчлөгдөөгүй явж байгаа. Гэтэл аль хэдийн өөрчилчихсэн байхгүй юу. Жил болгон өөрчлөөд яваад байсан. Тэгэхээр Цэдэвээ дарга та бүхэн маш тодорхой зөвлөмж өгөөрэй. Бид энэ сургалтын жишээ нь хөтөлбөр дээр саналаа өгнө тал талаасаа. Тэрнээс эс үгүй бол Засгийн газрын хуралдаанаар ороод, дараа нь 2 том байгууллагын нэг нь жишээ нь ЗГХЭГ-ын дарга бөгөөд Монгол Улсын сайд, нөгөөх нь Төрийн албаны зөвлөлийн дарга баталдаг. Ийм хошин шог шиг юм байж ерөөсөө болохгүй. Канадын та мэдэж байгаа төрийн албаны сургууль дээр бид нар очиж ажиллаж байсан та хэд очиж сайн мэдсэн байх. Эд нарт ийм юм байхгүй байхгүй юу. Бүүр сонсоод гайхаж байсан юм. Би очиж ажиллаад хууль дээр ийм юм чинь зохицуулалт нь ийм байгаа юм чинь гээд л хэлж байсан л даа.

Тэгэхээр энэ зүйлээс татгалзъя. Цаашлаад бол мэдээж хэрэг тэр сургалт хөгжлийн асуудал дээр бид онцгой анхаарах ёстой. Одоо бол бид энэ хуучин тэргүүн түшмэлийн, эрхэлсэн түшмэлийн гэдэг сургалтаас бүүр болимоор санагдаж байгаа юм. Бүүр ингээд залхмаар байна. Яг хэрэгцээнд нь тохирсон байдлаар тэгж сургалтуудаа модулиудаа гаргаж ирэх, тухайлсан сургалтууд гаргаж ирдэг ийм байдал руу оръё. Гэхдээ мэдээж хэрэг албан тушаалын шаардлагын сургалт байлгүй яах вэ. Гэхдээ хэрэгцээний сургалтыг бол нарийн хар.

**Б.Баярбаатар:** Ойлголоо Бадарчийн Хэрлэн гишүүн санал хэлнэ.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр түрүүн Гантөмөр гишүүн хэлж байна л даа. Төрийн албаны зөвлөл ер нь хяналт шалгалтын байгууллага болоод байгаа юм уу энэ чинь хөгжлийн байгууллага байх ёстой. Монгол Улсын төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах энэ ажлыг гардан хариуцаж байгаа энэ төрийн албыг хөгжүүлэх бэхжүүлэх ийм гол чиг үүрэгтэй байгууллага байх ёстой гэж түрүүн Гантөмөр гишүүн хэлж байгаатай би санал нэг байгаа. Тэгээд тэр хяналт шалгалтын байгууллагын дээр нэмэх нь тоо бүртгэлийн байгууллага болж хувираад байна уу гэж би хараад байна.

Хэрвээ энэ тоо бүртгэл дээрээ дүн шинжилгээ хийгээд цаашид засаж залруулах зүйлээ олж хараад арга хэмжээгээ аваад явдаг байх юм бол энэ сая хэрэг нь гарна. Тэгэхээр энэ дээр цаашдаа анхаарах хэрэгтэй байна гэж бодож байна. Тэгээд ер нь бол Төрийн албаны зөвлөл бас Төрийн албаны тухай хуульд бичигдсэн байгаа гол нэг зарчим төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах тухай ийм зарчим бол байгаа. Тэгэхээр 2024 оныхоо үйл ажиллагааны тайландаа танайхаас

бичсэн гол санаа юу байсан бэ гэхээр төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа цалин хөлсний тухай асуудлыг анхаарах шаардлагатай байна гэж санал дүгнэлтдээ бичсэн байдаг. Тэрэн дээр юу гэсэн бэ гэхээр төрийн албан хаагчийн цалин хөлсийг зохицуулж байгаа хууль тогтоомж ердөөсөө бараг 25 журмаар зохицоод Төрийн албаны тухай хуулиас гадна 25 журмаар зохицуулаад явчихаар чинь энэ цалин хөлсний нэгдмэл байдал, бодлогын нэгдмэл байдал алдагдаад байна. Энийг засаж сайжруулахгүй бол болохгүй нь гэсэн ийм дүгнэлтүүдийг хийгээд энэтэй холбоотой 2, 3 санаануудыг бичсэн байдаг. Тэгэхээр энэ дээр тэгж байгаа юм л даа. Ер нь бол орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин хөлсийг нэмээд явчхангуут яг төрийн захиргааных нь байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлс орхигдоод байна аа. Эд нарын асуудлыг яах юм гэх жишээтэй асуудлууд энд бичсэн байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр төрийн бодлого нэгэнт та нар яг энэ талынхаа ингээд 2024 оныхоо тайланд ингээд бичиж байсан. 2025 онд чинь та нарын үйл ажиллагаа ийшээ чиглэсэн байх ёстой.

Дээр нь сая 2025 онд чинь төрийн албан хаагчдын тоог бууруулах тухай ийм бүүр үйл ажиллагаа явуулчихсан байгаа үед яаж албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангах вэ? Цалин хөлсийг нь яах вэ? Энэ тухай дээр та нар яах аргагүй л анхаарах ёстой байсан. Танай Төрийн албаны тухай хуулиар та бүхэн энэ тал дээр одоо бас яг чиг үүргийнхээ хүрээнд санал зөвлөмж өгөх ийм эрхтэй байгууллага танайх, санал гаргах эрхтэй байгууллага. Танай чиг үүрэгт энэ бол хамаарах асуудал. Тэгэхээр энийгээ та нар хийх ёстой байжээ гэж би бодож байна.

Хоёрдугаарт нь би юу хэлэх гээд байна вэ гэхээр 2024 онд Үндэсний аудитын газраас Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн. Нэг ёсондоо Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн томоохон тайлан гарсан байгаа. Яг энэ тайлангийн мөрөөр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм? Юугаа засаж сайжруулсан юм? Энэ дээр та бүхний үйл ажиллагаа чиглэх ёстой байсан. Тэгэхээр энэ тухай асуудлууд энэ тайлан дотор орж ирсэн байгаа болов уу? Тэгэхээр чинь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хоорондоо уялдаатай байх ёстой, төрийн бодлого, залгамж чанараа хадгалах ёстой. Өнөөдөр нийгмийн эрэлт хэрэгцээндээ нийцсэн байдлаар бид нар бодлого үйл ажиллагаагаа авч хэрэгжүүлэх ёстой гээд энэ бүгдийг бодох юм бол яах аргагүй саяын асуудал бол энэ тайланд 2025 оны тайланд цалин хөлс нийгмийн баталгааны асуудал орхигдох биш харин бүр онцгой байр суурь эзлэх ёстой байсан.

Тэгэхээр дараа нэгдсэн магадгүй нэгдсэн чуулган дээр та бүхэн энэ үйл ажиллагааныхаа тайлангаа хэлэлцүүлэх байх. Тэр үедээ энэ дээр та бүхэн энийг онцгой анхаараарай гэж хэлмээр байна.

**Б.Баярбаатар:** Гишүүд санал хэлж дууслаа.

Хуралдаан даргалагчийн хувьд өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэхтэй холбогдуулж Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуульд нийцүүлэх хүрээнд тодорхой дараах үүрэг даалгаврыг протоколоор өгөх нь зүйтэй гэж үзэж байна аа.

Засгийн газарт

1.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврыг нь үнэлсэн үнэлгээний тайлан<sup>8</sup> үр дүнд үндэслэн Төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой төсөл боловсруулж 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өр өргөн мэдүүлэх.

Энэ дээр манай Зулпхар гишүүн онцгой анхаарал хандуулж, та Удирдлагын академийн захирал, Хөдөлмөр, нийгэм хамгааллын дэд сайдаар ажиллаж байсан учраас төрийн алба, төрийн албаны нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудал дээр уялдсан байдлаар өнгөрсөн хугацаанд хийсэн үнэлгээ, цаашид дутуу байгаа судалгааг хийж үргэлжлүүлээд. Тэгээд хуулийн төслийг боловсруулж намрын чуулганаар танилцуулах чиглэлийг өгч байна.

Төрийн албаны хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөлийн нэгдмэл бодлогыг хэрэгжүүлж Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулахтай холбоотой баримт бичгийн төслийг боловсруулж 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

3.Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх нэгдсэн бодлого, зорилтот хөтөлбөрийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

4.Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулах асуудлыг судалж 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулахад анхаарч ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

Хоёр.Төрийн албаны зөвлөлд

1.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхээр Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журмууд, Төрийн албаны хуулийн зохицуулалт үзэл баримтлалаас давсан зохицуулалттай байгаад нэг бүрчлэн үнэлэлт өгч, хуулиас давсан журмын зохицуулалтыг засах ажлыг нэн яаралтай хэрэгжүүлэх.

213611 Төрийн албан хаагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажиллах нь Төрийн албаны зөвлөлийн үндсэн чиг үүргийн нэг байхаар төрийн албаны хуулийн шинэчлэлд тусгахад анхаарах.

3.Төрийн албаны сургалтын чанар, хөтөлбөрийн агуулга, үр дүнд анхаарч сайжруулахад анхаарч хамтран ажиллах.

4.Төрийн жинхэнэ албаны шалгалтын агуулга, хэлбэрийг шинэчлэх, сонгон шалгаруулж томилох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сургах, дэвшүүлэх, шагнаж урамшуулахад асуудлыг шийдвэрлэхэд нэгдсэн арга зүйг боловсруулж хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагуудын мэргэшил арга зүйг зөвлөгөө үзүүлж ажиллах.

5.Төрийн албаны их өгөгдлийг бүрдүүлж аюулгүй байдал, нууцлалыг бүрэн ханган мэдээллийн системийг хиймэл оюунд суурилсан байдлаар хөгжүүлж бодлого

боловсруулах шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх. Сонгон шалгаруулалт, томилгоо, нөөц бүрдүүлэлт, шилэн систем, бодит цагийн горимоор ажиллуулах бэлтгэл ханган зохион байгуулах.

6.Төрийн албан хаагчийн ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэнд аюулгүй байдлын стандартыг боловсруулж батлуулах ажлыг 2027 онд багтаан зохион байгуулах.

7.Төрийн албаны хүний нөөцийн аудитыг эрчимжүүлж, чадахуйн зарчмыг бодитой хэрэгжүүлэхэд анхаарч сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

8.Улсын Их Хурлын 2019 оны Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай тогтоолыг чиг үүргийн шинжилгээнд үндэслэн шинэчлэн боловсруулж 2026 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахад анхаарч ажиллах шаардлагатай байгааг тэмдэглэн чиглэл болгож байна.

Гишүүд санал хэлж дууслаа.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаанд оролцсон гишүүд болон Төрийн албаны зөвлөлийн гишүүддээ талархал илэрхийлье ээ. Ажлын амжилт хүсье.

13.36 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА